

Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр -10
Шөнө -21

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЭЛЭЛД

ХЯТАД, МОНГОЛЫН УЛС
ТӨРИЙН МАРГААНД РИО ТИНТО
“ХЭЛМЭГДЧИХЖЭЭ”

III нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ЗОХИСТОЙ
АШИГЛАЖ, ХУЛГАЙН АНЧИДТАЙ
ТЭМЦЭХИЙГ ЭРДЭМТЭД ЗӨВЛӨВ

VI нүүрт

Дугаарын **60** мөр

Хямдрал нэртэй хямралтай худалдаа

Б.ДАВАА

Саяхан даа, саяхан. Хүнсний бүтээгдэхүүнийг шинээр нь хэрэглэгчиддээ нийлүүлдэг гэдгээ тодотгодог “Миний сүлжээ” дэлгүүрүүд бүх салбартаа зад хямдрал зарлах нь тэр. “Өргөн хэрэглээний 1000 нэр төрлийн бараа хямдарна”, “Өөр хаана ч байхгүй 100 нэр төрлийн жим ногоог худалдаална” гэх зар хаа сайгүй тарж, гэрийн хаалганы завсар сурталчилгааны зурагт хуудас нь ч хавчуулагдсан байхыг олж харав. Зурагт хуудаст нь дүрслэгдсэн итгэмээргүй хямд үнэтэй өргөн хэрэглээний барааг хямдрал зарласан хоёр хоногт яаж ийж байгаад олж авья хэмээн нөхөртэйгөө яришцаж, эхний өдрийнх нь үдээс хойш явж очлоо. Үнэн хэрэгтээ хүүхэд маань тахианы маханд нугасгүй. Энэ хямдралаар тахианы мах нэг кг нь 3990 төгрөг болсон гэж бичсэн байсан тул ийн яаравчлан очсон хэрэг. Гэтэл “дууссан” гэх худалдагчийн хүйтэн хариулт сонслоо.

Үргэлжлэл нь III нүүрт

АН-ЫН ИХ ХУРАЛ

АН-ЫН ИХ ХУРАЛ ШИНЭ САЛХИ СЭВЭЛЗҮҮЛЭХ ҮҮ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ж.ОТГОН

АН-ынхан 2007 оноос хойш нийтдээ есөн жилийн дараа ийнхүү Их хурлаа хийж байна. Их хуралд нийтдээ

1210 төлөөлөгч оролцож байна. Энэ хурлаараа АН үзэл баримтлал, үндсэн дүрмээ шинэчилж, намын даргаа сонгоно гэсэн мэдээлэл байгаа юм. УИХ, аймаг, орон нутгийн сонгуулиар

ялагдал хүлээсэн АН-ын шинэчлэл нийгэмд хүлээлт үүсгээд байгаа, Их хурлын төлөөлөгчид Чингисийн хөшөөнд хүндэтгэл үзүүлж, хонхны дуу эгшиглүүлсэнээр албан ёсоор

нээлтээ хийлээ. Хурлын эхэнд намын дарга З.Энхболд эдийн засаг болоод эрх баригчид руу чиглэсэн улс төрийн илтгэл тавьсан юм.

Үргэлжлэл нь IV-V нүүрт

ЗАЛУУСЫН ХОТХОН Apartment

АВАРГА, АРСЛАНТАЙГАА ХИЙМОРЬТОЙ АМЬДРАХ БОЛОМЖ

Энэ жилийн Үндэсний их баяр наадмын зүлэг ногоон дэвжээнээ үзүүр түүрх булаалдан, хүч үзэн барилдаж монгол түмнээ баясгасан **МУ-ын аварга Ч.Санжаадамба**, Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн тамирчин, дэслэгч, **МУ-ын арслан Р.Пүрэвдагва** нар **Залуусын хотхон “X Apartment”**-ын 2 өрөө орон сууцнаас **сонголтоо хийлээ**. Эрхэм танд Улаанбаатар хотын ерөнхий архитекторын баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө”-тэй уялдуулан дэд бүтэц сайн хөгжсөн, шинэ бүтээн байгуулалт өрнөж буй хотын “А” зэрэглэлийн бүсэд баригдсан орчин үеийн төлөвлөлт бүхий Залуусын хотхон “X Apartment”-ыг танилцуулж байгаадаа таатай байна.

Урьдчилгаа **10-20%** төлөөд байрандаа нүүж орох боломжтой **тансаг зэрэглэлийг илтгэх**, дотроо **2 давхар**, void буюу 2 давхараас шууд харагдах хоосон орон зай бүхий **Дуплекс загварын орон сууц**

24 цагийн харуул хамгаалалт, хүлээн авах ресепшн | С, D блокийн төв орцтой холбогдох хэсэг | Дулаан авто зогсоолтой | Таны мөнхийн залуу гоо сайханд зориулан мэргэжлийн салон | Таны хүүхдэд зориулсан монтеessori сургалттай цэцэрлэг | Таны гэр бүл найз нөхөдтэйгээ хамт байхад зориулан Кофе шоп | Таны урлагын мэдрэмжинд зориулсан уран зургийн галерей | Таны төмөр хүлэгт зориулсан Авто угаалга

TDB ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК | **ХААН БАНК** | **ТӨРИЙН БАНК** | **ГОЛОМТ БАНК** | **ХАСБАНК**

- ЗГ-аас харэгжүүлж буй 8% зээлээ 7 хоногт шийдвэрлүүлэх: Та 100% ашиглалтанд орсон орон сууцнаас сонголтоо хийж, бидэнтэй хамтран ажилладаг банкуудаар тусгайлан үйлчлүүлж 8% зээлээ 7 хоногийн дотор шуурхай шийдвэрлүүлэх таатай боломжийг санал болгож байна.

- Албан байгууллага, хамт олноороо сонголт хийснээр эдлэх тусгай хөнгөлөлт: Хамт олноороо орон сууцнаас сонголт хийж үнийн хөнгөлөлт, авто зогсоолын хөнгөлөлт, цэцэрлэгт хүүхдээ үнэгүй суралцуулах эрх зэрэг таны тав тухтай амьдрахад чиглэсэн бодит хөнгөлөлтүүдийг санал болгож байна.

- Бизнесмен танд зориулсан уян хатан нөхцөл: Та өөртөө болон хамт олондоо зориулан манай орон сууцнаас сонголт хийж, барилгын сайн чанарын материалууд болон арматураар харилцан ашигтай хамтран ажиллах боломж бүхий таатай нөхцлийг санал болгож байна.

- Банкны хүүгүйгээр өөрийн болгох боломж: Амжилтай яваа бизнесмен та өөрийн таалалд нийцсэн орон сууцыг бидний нэрлэсэн үнээр худалдан авч, төлбөрийн 50 хувийг төлөөд үлдэгдэл төлбөрөө 1-2 жилийн дотор хүүгүйгээр төлөх төлбөрийн нөхцлийг онцгойлон санал болгож байна.

ОРШИН СУУГЧДЫНХАА ТАВ ТУХ, ЭРҮҮЛ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭЖ ДЭЛХИЙД ЧАНАРААР ТЭРГҮҮЛЭГЧ БРЭНДҮҮДЭЭР “X APARTMENT”-ЫГ ТОНОГЛООО

VEKA ГЕРМАН ВАКУМ ЦОНХ | **TOTO** ЯПОН САНГИЙН ТОНОПОЛ | **LG Hausys** СОЛОНГОС ОБОЙ | **NIPPON PAINT** ЯПОН БУДАГ, ЭМУЛЬС | **EGGER** АВСТРИ ПАРКЕТАН ШАЛ | **ThyssenKrupp** ГЕРМАН ЦАХИЛГААН ШАТ | **AQUATHERM** ГЕРМАН ХОЛБОХ ХЭРЭГСЭЛ | **MEGAWOOD** МЕГАВУД ХААЛТА

Х-Апартментын хаяг: Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордоны зүүн урд талд
Захиалга авах хаяг: Сүхбаатар дүүрэг Улсын драмын театрын хойд талд “УЛААНБААТАР ПРОПЕРТИЗ” ХХК өөрийн байранд

www.xapartment.mn | www.ubproperties.mn | УТАС: 88002312, 88030203 | УТАС: 96066329, 77009919

ХААН Банк				Хуудалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2469.00	2478.00	ФУНТ	3094.00	3197.00	АМ.ДОЛЛАР	2465.00	2479.00
ЕВРО	2623.00	2692.00	РУБЛЬ	37.20	40.30	ЕВРО	2623.00	2711.00
ИЕН	21.51	21.88	ЮАНЬ	358.80	361.40	ИЕН	21.46	22.20
						ФУНТ	3107.00	3209.00
						РУБЛЬ	37.78	41.01
						ЮАНЬ	358.00	362.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

БАЙНГЫН ХОРОО

ОФФШОРТНУУДАД ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БУЦААВ



Э.МӨНХ

УИХ-ын Хууль зүйн байнгын хороо өчигдөр 10:10 цагт 52.6 хувийн ирцтэйгээр эхэлж, дөрвөн асуудал хэлэлцлээ. Хамгийн эхэнд Засгийн газраас энэ оны есдүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийсэн. Хуралдааны үеэр байнгын хорооны дарга Ш.Раднаасэд “АНУ-ын иргэд хүүхэддээ хатуухан үг ч хэлэх хоригтой байдгийн зэрэгцээ хүүхдүүд нь хууль, хяналтын байгууллагад гомдол гаргах тохиолдол их байдаг. Тэгвэл манай улсад ийм жишиг байхгүй. Бид бүхэн уламжлалт аргаараа л хүүхдээ хүмүүжүүлдэг. Өөрчлөлт шинэчлэл хийх гэж байгааг буруушаахгүй байгаа

ч Монголын хөрсөн дээр хэрэгжих боломжгүй зүйл гэж бий. Тиймээс жин банг нь тааруулах ёстой. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөлд орсон зарим нэг заалтыг өөрчлөх шаардлага байна” хэмэсэн. Мөн УИХ-ын гишүүн О.Баасанхүү гэр бүлийн хүчирхийллийг монгол уламжлалт аргаар шийднэ гэж байр суурьтай байгаагаа хэлсэн юм. Түүнчлэн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөлд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан сэргийлэх гэсэн хоёр зүйлийг тодорхой болгож өгөх хэрэгтэй”-г сануулав. Харин УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан О.Баасанхүү гишүүнийг өмгөөлөгчийн байр сууринаас хандаад байгааг буруушаалаа. Тэрбээр “Бид өөрийн орны уламжлалыг бодох хэрэгтэй. Яг үнэндээ хүүхэддээ юм хэлж

болохгүй болж байна. АНУ-ын хүүхдүүд 911 руу залгаад эцэг, эхээ хорлонд өгдөг. Түүн шиг асуудал болж хувирах вий дээ” хэмэсэн юм. Ямартай ч, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийх үеэр гишүүд нэлээд маргалдсаны эцэст зарчмын зөрүүтэй 60 гаруй саналаар санал хураахаар болсон. Гэвч Байнгын хорооны дарга Ш.Раднаасэд “60 гаруй зарчмын зөрүүтэй санал гарч байгаа нь энэ хуулийн төслийн нэр томьёо цэгцрээгүйг харуулж байна. Тиймээс хуулийн төслийг долоо хоног оройн хойшлуула” гэдэг санал гаргаж, гишүүд дэмжсэнээр дээрх хуулийн төслийг долоо хоног оройн хойшлуулав. Үргэлжлүүлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт

өөрчлөлт оруулах тухай болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийв. Гэвч Байнгын хорооны гишүүдээс нэлээд шүүмжлэл гарсан тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаахыг дэмжсэн юм. Хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан “Оффшор бүсэд 32 их наяд ам.доллар төвлөрч байна. Энэ мөнгө нь хөгжиж байгаа орнуудын өрнөөс хол давсан. Зөвхөн тэр мөнгөнөөс татварыг нь суутгавал зарим орны гадаад дахь өрийг бүрэн дарах боломжтой гэсэн судалгаа гарсан байна. Өнөөгийн нөхцөлд гадны улс орнууд Сангийн яам болон татварын байгууллагаатайгаа хамтарч тэдгээр мөнгөнхий эх үүсвэрийг шалгах, зохих татварыг нь төвлөрүүлэх, улс орон руугаа татах ажиллагааг идэвхтэй зохион байгуулж, ажлын хэсэг хүртэл байгуулж байна. Мөн тусгай хуулийн төсөл боловсруулж байна.

Зарим улс орнууд оффшор бүсэд хүүхдийнхээ нэр дээр данс нээсэн гэх удирдлагаа хүртэл шүүх өгчээ. Гэтэл манай улс оффшор бүсэд данстай улстөрчдийг хамгаалсан хуулийн төсөл оруулж ирлээ. Нэгдүгээрт, “албан үүргээ гүйцэтгэж байхдаа” гэсэн заалтыг оруулж өгсөн нь амарч сувилуулж байхдаа данс нээлгэж болно гэсэн агуулгыг агуулж байна. Хоёрдугаарт, оффшор бүс гэдгийг нарийн тодорхойлолгүй, зөвхөн гадаад дахь данс хэмээн тусгасан нь сурах, сувилуулах нэрээр данс нээх бололцоог бүрдүүлж өгчээ. Түүнчлэн гэр бүлийн гишүүдийг хуулийн үйлчлэлд хамруулахгүй байхаар оруулж өгсөн нь учир дутагдалтай байна” гэсэн юм. Ингээд УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан, Ц.Нямдорж нар дээрх хуулийн төслийг буцаах саналтай байгаагаа илэрхийлсэн тул тэдний саналыг байнгын хороо дэмжлээ. Мөн өнөөдрийн төсөл боловсруулж байна.

Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгуулах асуудлыг хэлэлцээд, ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Ц.Нямдоржоор ахлуулж, гишүүдээр нь УИХ-ын гишүүн Б.Батнасан, Б.Дэлгэрсайхан, Л.Энхболд, Л.Мөнхбаатар нарыг ажиллуулахаар болов. Хамгийн сүүлд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэх Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг авч хэлэлцсэн юм. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгээр Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг зөвхөн нэг удаа томилохоор заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцээд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн хэмээн үзэжээ. Иймд Үндсэн хуулийн цэцийн 12 дугаар дүгнэлтээр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн холбогдох заалтыг энэ сарын 2-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн аж. Байнгын хороо УИХ-ын гишүүн Ц.Нямдорж нар дээрх хуулийн төслийг буцаах саналтай байгаагаа илэрхийлсэн тул тэдний саналыг байнгын хороо дэмжлээ. Мөн өнөөдрийн төсөл боловсруулж байна.

MINFO
МОНГОЛЫН МЭДЭЭ
 18 дахь жилдээ
 Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТГОГО**
 Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**
 Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**
 Ахлах редактор: **Б.ӨНӨРТӨГТӨХ 88006842**
 Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**
 Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТӨГТӨХ 88006842**
 Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**
 Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**
 Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**
 Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**
Э.САЙНЗАЯА 99197866
 Дугаарыг эрхэлсэн **Н.ПУНЦАГБОЛД**
 Улсын бүртгэлийн дугаар: 907300528
 Индекс: 100757
 Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар. 209, 211 тоот**
 Харилцах утас, факс: **976-70113551**
 “Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ШАР
Д.Сумьяабазарын “вант улс” Сонгинохайрхан дүүрэг болох үү

 МАН засгийн эрх авч, 65-уулаа болсноор ёстой л нэг дураараа дургиж байна аа. Аль өнгөтэй, өөдтэй албанд ах дүү, хамаатан саднаа тавихаас гадна ямар ч үйл ажиллагаанд намынхаа нөхдүүдийг дэмжиж, компаниудыг нь татан оруулах нь энүүхэнд. Үүний тод жишээ нь, Сонгинохайрхан дүүрэг болж байгаа сурагтай. Учрыг тодруулбал, дүүргийн хэмжээнд ажиллаж буй бүх төрийн байгууллагуудын ажигчдын цалинг тус дүүргээс сонгогдсон Д.Сумьяабазар гишүүний хувь эзэмшдэг УХОБ-аар өгөхөөр болсон юм байх. Дүүргийн хэмжээнд аваад үзэхэд, 31 хороо, мөн тооны өрхийн эмнэлэг, цагдаагийн хэлтэс, сургууль, цэцэрлэг гээд л маш олон байгууллага бий. Энэ бүхэнд ажиллаж буй хүмүүс зөвхөн УХОБ-аар цалингаа авахын тулд мэдээж хэрэг карт захиалж таарна, дээрээс нь янз бүрийн гүйлгээний шимтгэл гээд л хөвөрч өгөх нь дамжиггүй. Үүнээс гадна тэр олон хүний цалинг төсвөөс байршуулчих болохоор хэсэгтэй л банк мөнгө эргэлдүүлэх боломжтой болох байх. Эрх мэдэлтэй хүмүүс ч мундаг юм аа, энд тэнд очиж, “вант улс”-аа байгуулаад л...

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ
С.Чинзориг гишүүний санаачилсан хуулийн төслүүдийг дэмжлээ
 НББСПУ-ны байнгын хороо өчигдрийн хуралдаанаараа зургаан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Хуралдаанаар “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Дээд боловсролын тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцож тухай хуулийн төсөл, “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” УИХ-ын 2012 оны аравдугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн юм. Эхний асуудлыг хэлэлцээд, зарчмын зөрүүтэй саналын томьёолуудаар санал хураалт явуулж, байнгын хорооны санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэхээр тогтосон юм. Дараа нь УИХ-ын гишүүн С.Чинзоригийн санаачилсан хуулийн төслүүдийг хэлэлцсэн юм. Ингээд зарчмын зөрүүтэй нэг саналын томьёоллоор санал хураалт явуулсныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн тул байнгын хорооны санал, дүгнэлтээ

чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар болсон. Мөн “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” УИХ-ын 2012 оны аравдугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үеэр УИХ-ын гишүүн С.Чинзориг, Үндэсний зөвлөлийн Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр ХЗДХ-ийн сайд ажиллахаар тусгасныг Эрүүл мэндийн сайд болгон өөрчлөх санал гаргасан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн. Мөн өдрийн хуралдаанаар “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг томилох, чөлөөлж тухай асуудлыг хэлэлцэж, зарын дагуу Үндэсний зөвлөлийн ажил олгогч болон даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр ажиллахаар нэрээ дэвнүүлсэн найман хүнээс гишүүд асуулт асууж, хариулт авсан юм. Хуралдаанд оролцсон гишүүдийн дунд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгох нууц санал хураалт явуулж, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр Э.Оюунтөгш, Н.Алгаа, даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр Ц.Сүхбаатар, Т.Батзүл нарыг ажиллуулах нь зүйтэй хэмээн гарсан тул чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэхээр болсноор хуралдаанд өндөрлөсөн юм.

Монгол, Оросын Хууль зүйн яам хамтран ажиллана

 УИХ, Засгийн газрын гишүүн, ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт ОХУ-ын Дотоод хэргийн сайдын урилгаар тус улсад ажлын айлчлал хийж байна. ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт тус улсын Хууль зүйн сайд Александр Владимирович Коноваловтой уулзаж, энэ жил хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 95 жилийн ой тохнож буйг онцлоод хоёр улсын яамдын уламжлалт хамтын ажиллагааг цаашид баяжуулан өргөжүүлэх өргөн боломж байгааг тэмдэглэв. Мөн Монгол Улсын Засгийн газар, тэр дундаа ХЗДХЯ эдийн засаг, бизнес, өмчийн харилцааны хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлд онцгой анхаарч ажиллаж байгаа талаар мэдээлэв. А.В.Коновалов урилгыг нь хүлээн авч, хүрэлцэн ирсэнд С.Бямбацогт сайдад талархаж буйгаа илэрхийлээд ОХУ-ын Хууль зүйн сайдын эрхлэх асуудалд


Холбооны хорих ял эдлүүлэх байгууллага, Холбооны шийдвэр гүйцэтгэх байгууллага, Шүүхийн шинжилгээний төв, Эрх зүйн мэдээллийн эрдэм шинжилгээний төв зэрэг байгууллага ажилладаг болохыг танилцуулав. Талууд Монгол Улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажилладаг болохыг онцлоод тус хэлэлцээрийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах тал дээр санал нэгдэв. Мөн хоёр сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжин тэлж байгааг тэмдэглээд Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

ерөнхий газар болон ОХУ-ын Ял шийтгэл гүйцэтгэх холбооны албатай хамтын ажиллагааны санамж бичиг харилцаа, хамтын ажиллагаа идэвхжихэд түлхэц үзүүлж байна гэв. Талууд эрх зүйн хамтын ажиллагаа, хууль тогтоох, тусгай албадыг хөгжүүлэх гээд бүхий л чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон юм. Уулзалтын төгсгөлд хоёр улсын яамд хооронд 2017-2018 онд хамтран ажиллах хөтөлбөрт сайд нар гарын үсэг зурлаа. Энэхүү хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх нь манай хоёр орны эрх зүйн салбарын хамтын ажиллагааны хөгжилд онцгой ач холбогдолтой ажээ.

Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Одон орон, геофизикийн судалгааны төвийн Тазар хөдөлмөр судлах секторын эрхлэгч

М.Олзийбайн

“**Ààçàð ò°àè°èò àí èàí í òí òèðí è ò-ðòóèààà ààèààà òì . Ààçàð ò°àè°èò, àýýð í ù ì óóàí ò°è°àè°í òí ò ààèààè ì àø èò òí òèðí è ààðààà.**
Æèøýý í ù, Ààèòè. Õýíà ààçàð ò°àè°ò°à 300 ì ýíààí ò;í çð÷èòíýí.
Èààààà àýàýè, ààçàð ò°àè°èò àí èí òóà òí òà;é ýàñààð ààèàààà òýð. Èààààà Òèààí àààòàðð òàçàð ò°àè°ò í ù àýè òàí àðàèàààà, ýàðàèòàé àðàà òýì àýý àààòóòèàò àýýà à;éàýýà ààèí à àý àýòýýð ì àí àèò Ààèòè ø;ì àýý.”

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

ХЯТАД, МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН МАРГААНД РИО ТИНТО “ХЭЛМЭГДЧИХЖЭЭ”

Б.ДАВААХУУ

“Оюу Толгой” компани зэсийн баяжмалын экспортоо тодорхойгүй хугацаагаар зогсоож буйгаа мэдэгдсэн. Энэ нь Хятадын талаас хилийн боомтоор нүүрс болон зэсийн баяжмалын тээвэрлэлтийг нэг замаар хийх шаардлага тавьсангай холбоотой бөгөөд экспорт хийхийн тулд удаан хугацаанд хил дээр дугаарлах байдал үүссэн нь хүндрэл үүсгэж, дээрх арга хэмжээг авахад хүргэжээ. Харин Хятадын талаас нэг замаар зэс, нүүрсний тээвэрлэлт хийх хийгээд ганц модны боомтоор гаргаж буй бүтээгдэхүүнээс хураамж авахаар шийдвэрлэсэн зэрэг нь дээрхийн гэгээнтэн Далай ламын Монгол

Улсад хийсэн айлчлалтай холбоотой гэж зарим дэлхийн хэвлэлд мэдээлсэн байна. Нэг үзээр хэлбэл, Хятад, Монголын улс төрийн маргаанд “Рио Тинто” групп хэлмэгдэж буй бололтой. Гэхдээ “Рио Тинто” бол манай улсын хамгийн том татвар төлөгч юм. Тус компанийн хувьд энэ онд 175-195 мянган тонн нүүрс, 255000-285000 унц алт олборлохоор төлөвлөсөн ч, хилийн боомтын шинэ зохицуулалтын улмаас төлөвлөгөөгөө биелүүлж чадахгүйд хүрч болзошгүй юм. Цаашлаад Монголын эдийн засагт ч нөлөөлөхийг үгүйсгэх аргагүй. Ингээд энэ удаагийн Монгол дэлхийн хэвлэлд булантаараа уг асуудлыг хөндөж, гадаадын хэвлэлд аль өнцгөөс хэрхэн мэдээлснийг хүргээ.

Turquoise Hill suspends Mongolia mine shipments to China

By Susan Taylor
 TORONTO, Dec 2 (Reuters) - Turquoise Hill Resources Ltd said on Friday it has suspended concentrate shipments from its giant copper-gold Oyu Tolgoi mine in Mongolia across the Chinese border, blaming problems with a crossing route.

Vancouver-based Turquoise Hill said it suspended shipments effective Thursday, after a new requirement at the Chinese-Mongolian border to use one joint coal and concentrate route created “unreasonably” long waits to cross the border along with safety and security concerns.

The company, whose shares fell 2.5 percent to C\$4.34 in early trade on Friday, said in a statement it was unclear how long the suspension would continue and it was trying to clarify the matter with Mongolian and Chinese authorities.

Turquoise Hill was not immediately available for comment.

finance.yahoo.com: Рио Тинто Хятад, Монголын Засгийн газраас асуудлыг тодруулж байна

“Туркойз Хилл Ресорсез” компани өнгөрөгч баасан гарагт Монголын асар том зэс, алтны уурхайгаас Хятадын хилийн боомтыг дамжин өнгөрөх экспортоо тодорхой асуудлын улмаас тодорхойгүй хугацаагаар зогсоож буйгаа мэдэгдсэн. Хятадын талаас Хятад-Монголын хилээр зэсийн баяжмалыг нүүрстэй нэг боомтоор дамжуулан тээвэрлэх шинэ шаардлагыг гаргаснаар Ванковерт төвтэй “Туркойз Хилл Ресорсез” компани бүтээгдэхүүний экспортыг түр хугацаанд зогсоохоос өөр аргагүй болжээ. Тэдний хувьд энэхүү шинэ шаардлага нь хил дээр удаан хугацаанд хүлээлт үүсгэхээс гадна ажилтнуудын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхийг байж боломгүй шийдвэр гэдгийг онцолж байна. Мөн цаашид экспортын түр зогсолт хэдий хугацаанд үргэлжлэх нь тодорхойгүй байгаа бөгөөд Хятад, Монголын эрх баригчдаас үүсээд буй асуудлыг тодруулахыг оролдож байгаа ажээ. Энэ онд Өмнөговийн уурхайгаас 175-195 мянган тонн нүүрс, 255000-285000 унц алт олборлохоор төлөвлөсөн хэмээн тус компани өнгөрөгч арваннэгдүгээр сард мэдээлж байв. Түвдийн бурхны шашны тэргүүн Далай лам өнгөрсөн долоо хоногт Улаанбаатарт айлчилсны дараа Хятад-Монголын хооронд бүтээгдэхүүн тээвэрлэлтэд шинэ хураамж ногдуулах шийдвэр гаргасан байдаг. Буддын шашинтнууд хүн амын олонхийг эзлэх Монголд Далай ламыг ихэд хүндэтгэн биширдэг бол Хятад аюултай салан тусгаарлагч гэж үздэг бөгөөд энэ удаагийн айлчлал хоёр улсын харилцаанд сөргөөр нөлөөлөхийг удаа дараа анхааруулж байсан. Рио Тинто Оюу толгойн 66 хувийг, харин үлдсэнийг нь Монголын Засгийн газар эзэмшдэг байна.

www.theaustralian.com.au: БНХАУ, Монголын улс төрийн хэрүүлд Рио Тинто групп хэлмэгдэж эхлэв



Монгол улс төрийн маргаанд Рио Тинто групп хэлмэгдэж эхлэв. Тус групп нь Монголын хамгийн том татвар төлөгч бөгөөд алт, нүүрсний түүхий эдийн ордны ихэнх хувьцааг эзэмшдэг. Гэвч Түвдийн шашны удирдагч Хятадын сануулгыг үл тоон Монгол Улсад айлчилсны дараа Оюу Толгойн уурхайн бүхий л бүтээгдэхүүний экспортыг Хятадын талаас хязгаарлаж эхэлжээ. Тодруулбал, тус улсын албаныхан зэсийг нүүрстэй нэг хилийн боомтуудаар дамжуулан экспортлохыг шаарджээ. Гэвч зэсийн баяжмалыг нүүрстэй нэг боомтоор дамжуулан тээвэрлэх хасах хэмийн хүйтэнд жолооч нар удаан хугацаанд дугаарлах шаардлага гарах бөгөөд энэ нь аюулгүй байдлын үүднээс ноцтой хүндрэл учруулж буйг Рио Тинтогийн зүгээс онцолж байна. Үүний улмаас өнгөрөгч баасан гарагаас эхлэн бүтээгдэхүүний экспортоо зогсоожээ. Хилийн боомтын энэ мэт хязгаарлалт нь Далай ламын Монголд хийсэн дөрвөн өдрийн айлчлалтай холбоотой Монголын эсрэг авсан арга хэмжээнүүдийн нэг юм. Өмнө нь Таван толгой нүүрсний уурхайг холбох төмөр замын бүтээн байгуулалт, мега төслүүд, зээл тусламжийг хэлэлцэх хоёр талт хэлэлцээүүдийг Хятадын талаас цуцалсан байдаг. Буддын шашинт Монгол Улсад далай лам 1979 оноос хойш хэд хэдэн удаа айлчилж байжээ. Рио Тинто групп дэлхийн 40 гаруй улсад 55 мянган ажилчинтай бөгөөд Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Туркойз Хилл Ресорсез компаниар дамжуулан Оюутолгойн ногдол хувийг эзэмшдэг. Зургадугаар сард компани 5.3 тэрбум ам.долларын санхүүжилтээр газар дорх бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн. Энэхүү бүтээн байгуулалт нь 2020 онд

анхны олборлолтоо хийх бөгөөд 2027 оноос бүрэн хүчин чадлаараа ажиллаж, жилд 500 мянган тонн бүтээгдэхүүн олборлоно хэмээн шинжээчид тооцсон байдаг. Улмаар энэхүү төсөл бодит байдал биеллээ олсноор Монголын эдийн засгийг бодитойгоор гурав дахин нэмэгдүүлэх тооцоо гарчээ. Гэхдээ Оюу толгойн хамгийн их санаа зовоосон асуудал нь эдийн засгийн энэхүү өсөлтийн дараа саяхны явдал шиг Хятадын хэт хараат байдал хүндрэл үзүүлж болзошгүй оршиж байна. Гэхдээ Монголын нүүрсний салбарынханд төсөөллийг их боломж нээгдэж байгаа юм. Учир нь Бээжин дотоодын уурхайг цагийн хязгаарлалт хийж, цахилгаан станц, ган үйлдвэрлэлийн импортоо нэмэгдүүлэхэд анхаарч байгаа билээ.

www.channelnewsasia.com: Гашуун сухайтын боомтоор сар бүр 133 мянган тонн зэсийн баяжмалыг Хятад руу тээвэрлэдэг

Түвдийн шашны тэргүүн Далай лам Улаанбаатар хотод өнгөрсөн долоо хоногт айлчилсантай холбоотойгоор Хятад Монголын хилийн гол боомт дахь бүтээгдэхүүний тээвэрлэлтэд шинэ хураамж ногдуулжээ. Рио Тинто группын хувьд Оюу Толгойн уурхайгаас зэсийн баяжмалаа Гашуун сухайтын боомтоор дамжуулан экспортлодог бол Хятадын төрийн мэдлийн Шенхуа групп ч гэсэн Таван толгойн нүүрсийг тус боомтоор дамжуулан тээвэрлэдэг. Тэгвэл Хятадын хилд орших Өвөрмонголын өөртөө засах орны хилийн боомт дамжин өнгөрөх тээврийн хэрэгсэл бүрт 10 юаны хураамж, тээвэрлэсэн ачаанаас тонн тус бүрээс

найман юаны хураамж авах шийдвэрийг орон нутгийн удирдлагууд гаргажээ. Мөн нэг тонн нь 10 мянган юаниас давсан үнэт металл, зэсийн баяжмалаас хоёр хувийн хураамж авахаар шийдвэрлэсэн байх бөгөөд энэ нь арванхоёрдугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн байна.

Монголын металл, уул уурхайн салбарын судалгааны судлаач Дале Чойн хэлж буйгаар Гашуун сухайтын боомтоор өдөр бүр 900 ачааны машин дайрч өнгөрдөг бөгөөд сар бүр 133 мянган тонн зэсийн баяжмалыг Хятад руу тээвэрлэдэг байна. Буддын шашинтнууд хүн амын ихэнхийг эзлэх Монголд Далай ламыг хүндэтгэн биширдэг. Гэсэн хэдий ч, Хятадд түүнийг салан тусгаарлагч этгээд хэмээн үздэг бөгөөд айлчлал хоёр улсын харилцаанд сөв суулгаж биелэшгүйг анхааруулж байв. Гэхдээ хилийн боомтын зохицуулалтын талаар БНХАУ-ын Гадаад хэргийн яамнаас албан ёсоор мэдэгдэл хийж, Далай ламын айлчлалтай хамаатуулаагүй ч, тус яамны төлөөлөгч Жен Шуан өнгөрсөн сарын мэдэгдэлдээ Монгол Улс Далай ламын айлчлалтай холбоотой сөрөг нөлөөг арилгахын тулд үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатайг онцолж байсан удаатай. Үнэхээр ч Монголын дипломат харилцаанд сөв сууж, хоёр улсын эдийн засгийн харилцааг сайжруулах, уул уурхайн дэд бүтцийн төслүүд, Хятадаас хөрөнгө оруулалт татах гэх мэт яриа хэлэлцээрүүд цуцлагдаж эхэлснээр хямралд нэрвэгдсэн тус улсын Засгийн газарт хүндхэн цохилт болж магадгүй байна. Засгийн газрын төлөөлөгч Г.Отгонбаяр өнгөрсөн долоо хоногт твиттер хуудсаараа дамжуулан арван нэгдүгээр сарын 28-нд товлогдсон хоёр талт уулзалтыг Хятадын талаас цуцалсан гэдгийг мэдэгдсэн удаатай.

Дугаарын 60 мөр

Хямдрал нэртэй хямралтай худалдаа

Үргэлжлэл. Түүрүүч нь I нүүрт

Гэхдээ дэлгүүрийн хөргөгчөөр нь дүүрэн тахианы мах байхыг хараад тэрүүхэндээ зогтосч, “Эхний өдөр нь байтал яагаад дуусдаг билээ” гэж асуув. Цэнхэр өнгийн ноосон цамц өмссөн худалдагч бүсгүй “Хямдралтай зарж байсан тахианы мах нь дуусчихсан. Эдгээр махыг үндсэн үнээр нь худалдаална” гэлээ. Хөргөгчөөрөө дүүрэн махтай атлаа хямдралтай нь дуусчихсан гэж хэв нэг хариулж буй тэднийг хараад нэг зүйлд гайхлаа. Үлдсэн мах нь хямдрахгүй юм бол нийслэлчүүд бид ямар мах зад хямдарсан үнээр авчихсан хэрэг вэ. Нөгөөтэйгүүр, хоёр өдөр хямрал зарласан атлаа эхний өдөр нь бараа нь дуусчихдаг үндэсний томоохон сүлжээ дэлгүүрүүдийг ялтай вэ. Хоёр өдөр гэж хэрэглэгчдийн хуурахыг оронд нэг өдөр хямдарсан шиг хямдарвал дээрсэн. Өмнө нь “Дархан нэхий” ХХК ч ногоон “Бөмбөгөр” худалдааны төвийн дөрвөн давхрыг эзлэн хямдралтай худалдаа явуулсан ч, мөн л агуулахдаа зарагдаагүй удсан гологдол бараагаа нийслэлчүүдэд хямдрал нэрээр шахсан. Бас болоогүй өнгөрөгч онд “Номин”-гийнхон Америк маягийн “Хар баасан гараг” хэмээх супер хямдрал зарлаж, электрон бараа, гэр ахуйн бараа, гоо сайхан, бутуйн цаг, хувцас, сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүн, америк хүнс, герман обойны олон олон онцгой бараануудаа хямдруулдаг юм байна. Сурталчилгаандаа ингэж бичсэн хэрэг л дээ. Гэтэл угаас үнэгүй юманд нугасгүй монголчууд Номингийн ойр хавьд цугларч, урьд хожд үзэгдэгийг түгжрөлийг үүсгэснийг уншигчид санаж буй бий. Хямд бараа авах байгуулай, амьд гарсандаа хүмүүс баярлаж байсан санагдана. Тэнд иргэд хямдралтай бараа авахаар тэмцэлдэж байхад үнэндээ хямдарсан бараа байгаагүй л юм даг. Юун “Хар баасан гараг”, Америк бол “Хар баасан гараг”-ийн хямдралыг жинхэнэ утгаар нь зохион байгуулдаг. Жил бүрийн арваннэгдүгээр сарын гурав дахь долоо хоногийн пүрв гарагийн маргааш дэлгүүр, худалдааны төв, сүлжээ дэлгүүрүүд шинэ жилийн баяр угтсан худалдаагаа эхлүүлж, бараа бүтээгдэхүүнийхээ үнийг зад хямдруулдаг учир худалдан авагчид ч энэ өдрийг тэсэн ядан хүлээдэг гэдэг. Гэтэл манайд хямралыг далимдуулсан хэдэн сүлжээ дэлгүүр, супермаркетууд хуучин үнийг нь өсгөж тавиад, түүнийгээ хямдруулаа гэж үйлчлүүлэгчдээ хуурдаг байх жишээтэй. Аль эсвэл үйлдвэрийн гологдол бараа, хугацаа нь дуусах дөхсөн бүтээгдэхүүнээ үндсэн үнээр нь хямдруулан худалдаалах бөгөөд түүнийгээ хямдрал гэх нь бий. Гэвч үнэн хэрэгтээ энэ нь хямрал биш. Ер нь ч тэгээд хямдрал нэртэй “хямрал” зарлаж байхаар жилдээ нэг удаа ч болов жинхэнэ утгаар нь хямдралыг иргэддээ мэдрүүлчихдэг баймаар юм. Бүх дэлгүүр биш юм аа гэхэд, үндэсний тодотголтой хэдхэн үйлдвэр нь ядаж хэрэгжүүлчихдэг болчихвол дээр сэн.

УЛС ТӨР

АН-ЫН ИХ ХУРАЛ

АН-ЫН ИХ ХУРАЛ ШИНЭ САЛХИ



Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

Үргэлжлэл.
Түүрч нь I нүүрт

Энэхүү илтгэлээрээ засгийн эрхийг барьж байгаа МАН-ын амлалт, бодлогыг шүүмжилж, өнгөрсөн таван сар АН-ын бодлогуудыг шүүмжилсэн эрх баригчдын улстөржилтөд хатуухан харуулт өглөө. Үүний дараа АН-ын шинэтгэлийн хөтөлбөрийг УИХ-ын гишүүн асан Х.Тэмүүжин танилцуулсан юм. Тэрбээр "Ардчилсан намд эв нэгдэлтэй байж чадаагүй гэдэг. Гэхдээ эв нэгдэлтэй байна гэдэг МАН шиг

муу, муухайгаа нууна гэсэн үг биш ээ. АН-ын эв нэгдэл бол фракц дагаж гүйх биш дүрмэн дээрээ нэгдэхийг хэлнэ. АН бүх шатны эрх мэдлээ шат, шатандаа тодорхой болгохгүй бол давхацсан эрх мэдэл хагаралдуулдаг. АН-ыг нэг толгойтой болгохын тулд яаж нэг нам болгох вэ гэдгээ шийдэх ёстой. Улс орныг хөгжүүлэх хамгийн гэрэл, гэгээтэй санаачилгыг бид гаргаж чаддаг. Түүнийг хэлэлцүүлгийг нам дотроо хийхгүй бол болохгүй байна. Бид аливаа шийдвэрийг зөвшилцлийн зарчмаар, гэхдээ дүрмээ сахиж, цөөнх

болсон нь олонхийн шийдвэрээ дагаж, олонх нь цөөнхүү хүндлэхгүй бол бид цүнх барьсан хүмүүс, фракцид хуваагдсан хүмүүсийн тэмцлийн талбар болно. АН-д шинэ салхи хэрэгтэй байна. Тогтмол ус үмхийрдэг. Тиймээс хаалга үүдээ сайн нээх хэрэгтэй. Намын бүртгэлийг цахимжуулж, тэр нь нээлттэй байж хуйвалдааны намаас салах цаг болжээ. Нээлттэй, оролцоотой, цахим ардчилсан нам гэдэг энэ хурлаас гараад 2017 оны хоёр сард шинэ намын тогтоцтой, шинэ даргатай, гишүүдтэй болно" гэв. Шинэтгэлийн

хөтөлбөрт АН-ын ҮЗХ-г 330 хүнтэй болгох, Гүйцэтгэх зөвлөлийг Ерөнхий зөвлөл болгох, ҮЗХ-ны гишүүдийн нэг жилийн татварыг таван сая төгрөгөөр тогтоож байгаа юм байна. Ийнхүү АН-ын VI Их хурал түр завсарлаад, одоо төлөөлөгчид санал шүүмжлэл хэлэх агшинд хуралдааныг хаалттай горимд шилжүүлээ. Санал шүүмжлэлээр намын даргын үйл ажиллагаа, 2016 оны УИХ-ын сонгуулийн ялагдал, нам шинэчлэгдэх процесс, намын дүрэм тойрсон заалт зэрэг асуудал хөндөх юм. Уг хуралд 21 аймаг, нийслэлийн есөн

дүүргийн Ардчилсан намын 1000 гаруй төлөөлөгч оролцож байна. Тэдний 800 гаруй эрэгтэйчүүд бол 200 гаруй нь эмэгтэй гишүүд юм. Мөн гишүүдийнх нь 858 нь дээд боловсролтой бол 250 гаруй нь эрдмийн зэрэг цолтой аж. Энэ удаагийн Их хурлаас Ардчилсан намынхан намын дүрмийн шинэчлэлээ хэлэлцэн, батална. Үүний дараа анхан, дунд шатанд сунгаа явж, Үндэсний зөвлөлдөх хороо, Их хурлын гишүүдийг шинээр сонгох үйл явц эхэлнэ. Ингээд Их хурлын үеэр зарим гишүүдийн байр суурийг сонслоо.

3.Энхболд: МАН сонгуулиар мөнгө тараасан ч хууль, шүүхийнхэн нүүдээ аниаг өнгөрсөн



/АН-ын дарга/

-Сонгуулийн үед царцааны нүүдлээс болж Хөвсгөл, Увс, Баянхонгор зэрэг аймагт АН 10-аадхан саналаар ялагдсан. УИХ-ын сонгуулиар нэг хүний саналыг дахин дахин өгсөн ноцтой асуудал гарсан. МАН сонгуулиар мөнгө тараасан. Гэвч хууль, шүүхийнхэн нүүдээ аниаг өнгөрсөн. МАН-ыг засагтаа оруулсан нь Үндсэн хуулийг өөрчлөх явдал байсан. Үндсэн хуулийг өөрчилж чадаагүй. АН-ыг хагаралдуулах оролдлого удаа дараа гарсан. Ардчиллаар замнасан 26 жилд аль нэг нам дараалан ялалт байгуулсан удаа байсангүй. Дөрвөн жилд нэг удаа эрх баригчдаа сольдог сонгогчтой болжээ. Сүүлийн долоон сонгуулиар сонгогчид дөрвөн жил тутамд эрх баригч намаа сольж ирсэн. Үүнээс харахад, ард түмэн маш богино хугацаанд үр дүнг харж байдаг. Найм дахь сонгуулийн үр дүнг таавал хэрвээ бид сөрөг хүчний ажлаа сайн хийвэл, одоо хийх шинэчлэлээ сайн хийвэл 2020 онд АН ялах боломжтой. Бид улс төрийн тавцанд гол тоглогч байсаар байгаа. Сонгуульд 65 суудал авчихаад МАН сонгуулиар амалсан амлалтаасаа буцаж, өнгөрсөн дөрвөн жил хийсэн ололтоосоо ухарсан. Ямар засгийн газар байгуулсныг та бүхэн харж байгаа. Би АН-ын даргаар хоёр жил ажилласан. АН-ыг би фракцигүй,

бодлогын нам болгохоор зорьсон. Намын даргыг намын нийт гишүүдээс сонгогддог байх нь зөв гэдэг бол манай намын бодлогын томоохон шинэчлэл болно. Ардчилсан нам өөрийн байгуулсан засгаа унагах нь бодлогын өрсөлдөөн биш гэдгийг хүлээн зөвшөөрч, үүнийг дахин гаргахгүйн тулд дүрмээ өөрчлөх ёстой. МАН-ынхан бондын мөнгийг ард түмэн төлнө гэж улстөржүүлээд байна. Тус нам гишүүдийнхээ авсан зээлийг ард түмнээр төлүүлнэ гэж ямар ч тохиолдолд байхгүй. МАН-ын ургийн мод өдрөөс өдөрт нахиалан цэцэглэж байна. Дэлхийн энх тайвны бэлгэ тэмдэг Далай багш Монголд өмнө нь ирж л байсан, явж л байсан. Энэ бүхнийг бид дипломат аргаар шийддэг байсан. Тэгсэн өнөөдөр хилийн хураамжаа нэмэгдүүлж, бүх албан ёсны хэлэлцээрээ зогсоочихоод буруутанг хайж байна. МАН ажлаа хий. Цөөн тооны Монголын улстөрч оффшор данстай, оффшор компанитай байгаа талаар их ярьж байна. Манай УИХ, Засгийн газар оффшортой эвлэрэхгүй байх юм бол хуулийн хяналтынхнаар асуулгахад мэдээлэл авах бүрэн нээлттэй болсон. АН-ын үед эрдэс баялгийн үнэ тасралтгүй өсч байсан бол МАН-ын үед коксжих нүүрний үнэ өслөө. Эрх баригч МАН-ынхан дөрвөн тэрбумын ор тавихаар 40 сая тонн нүүрсээ зар. МАН-ын төрийн ажлын туршлагагүй, мэргэжлийн бус сайд дарга нар, Монголбанкны ерөнхийлөгч нар зөвхөн АН-ыг гутаан доромжилсноос болоод эдийн засаг уналтад орсон. Ийм хүмүүстэйгээ хариуцлага тооц.

Л.Эрхэмбаяр: Одоогийн байгалаар 4-5 хүн намын даргаг өрсөлдөхөө мэдэгдсэн



/АН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч/

-АН улс төрийн намынхаа хувьд төлөвшилийн шинэ үе шатанд ирж байна. Шинэтгэлийн асуудал бол зөвхөн зургадугаар их хурлаар хийгдээд зогсчих дуусчих асуудал биш. АН-ыг фракцад хуваагдсан хувьчлагдсан гэсэн шүүмжлэлийг жирийн гишүүдээс ирүүлж байгаа. Тиймээс бүртгэлийг цахимаар хийдэг бол, харууцлагын тогтолцоотой бол, нээлттэй ил тод зарчимд шилжнэ, итгэл даадаг нам болж төлөвшнэ гэдэг зарчмын асуудлуудыг АН-ын шинэтгэлийн хөтөлбөрөөрөө хэлэлцэж батлах гэж байна.

Шинэтгэлийн хөтөлбөр бол манай намын ойрын дунд хугацаанд баримтлах үндсэн чиг баримжаа болох юм. Энэ шинэтгэлийн нэг хэсэг нь АН-ын дүрэмд өөрчлөлт оруулснаар эхэлж байгаа юм. Энэ дүрмээр АН-ын даргыг нийт саналын эрхтэй гишүүдээс сонгодог бол, гэсэн зарчим өөрчлөлтийг оруулж байгаа. АН-ын дунд шатны байгууллагын дарга нарыг өөрөөр хэлбэл, аймаг нийслэл дүүргийн намын дарга нарыг зөвхөн намын хорооны гишүүдээс биш өргөсөн төлөөлөөр ил тод сонгоё гэсэн санал гаргаж байгаа. Эдгээр саналыг хэлэлцээд маргааш /өнөөдөр/ бараг батлах байх. Нэгдүгээр сарын 08-ны хүртэл АН-ын нийт гишүүдийн шинэчлэлийн бүртгэл явагдана. Үүний дараа нэгдүгээр сарын 22-нд улс орон даяар 330 сум есөн дүүрэгт бүх анхан шатны намын үүрүүдийн хурал болно. Энэ хурлаар намын үүрийн дарга нараа нээлттэй

ил тод сонгоно. Дараа нь буюу нэгдүгээр сарын 29-ний хавьцаа бүх шатны сонгуулиуд явагдана. Аймгийн зөвлөлдөх зөвлөлийн гишүүний сонгууль, ҮЗХ-ны сонгууль, нийслэл, дүүргийн сонгуулиуд болно. Үүний дараа хоёрдугаар сарын 20-доор орон даяар сунгаагаар намын даргаа сонгох ажлуудыг төлөвлөж байна. Намын даргын тухайд одоогийн байдлаар 4-5 хүн намын даргад өрсөлдөхөө мэдэгдсэн байгаа. Гэхдээ 10 нь ч хүн дэвшиж магадгүй. Тэгвэл 10-ууланг нь өрсөлдүүлэх үү гэдэг асуудал гарч байгаа. Тийм учраас үүнийг хоёр шаттай болгоё гэсэн санал гарч байгаа. Эхний шат нь ҮЗХ дээр хамгийн өндөр санал авсан дөрвөн хүнийг цааш нь явуулах гэсэн санал гаргасан. Тэгэхгүй бол сонгон салгаруулалт явуулахад их төвөгтэй байгаа. Тэр дөрвөн нь улс орон даяар марафонд ороод явдаг бол, гэж байгаа юм. Ийм төсөл орж ирж байгаа.

Ж.Батзандан: АН шинэчлэгдсэнээр Монголын ардчилал шинэчлэгдэнэ



/УИХ-ын гишүүн/

-Намын эв нэгдэлийг хангах дүрмийн өөрчлөлтийг бий болгохоор ажиллаж байна. Энэ удаагийн өөрчлөлт маш том өөрчлөлт байх болно. Цаашид намын дүрмийн өөрчлөлтийн хүрээнд бид намаа шилэн нам болгоё, АН-ын бүртгэлийн системийг илүү сайжруулах, АН төрийн болон дотоод сунгаанаа шударга явуулдаг тэр тогтолцоог бий болгохыг зорьж байна. Бүх шатны намын дарга нарыг гишүүд дэмжигчдээс сонгодог

тогтолцоо руу орох томоохон өөрчлөлтийн саналууд өнөөдрийн /өчигдөр/ хуралдаанаар хэлэлцэгдэнэ. ҮЗХ-ны 228 гишүүн байж байгаад сүүлд өргөжөөд 256 болсон. Дүрмийн шинэчлэлээр 304 орчим болгох санал гарсан. Үүн дээр шууд суудал гэж бий болж байгаа. Энэ нь УИХ-ын гишүүн болсон АН-ын гишүүн ҮЗХ-нд шууд сууна. Ингээд ҮЗХ нийт 350-360 гишүүнтэй болж байгаа. Одоогийнхоос 100-гаар нэмэгдэнэ гэсэн үг. Өнөөдрийг хүртэл шат шатны хурлууд намын даргын асуудлыг л ярьдаг байгаа. Намын дарга хэн болохоос хамаараад, фракц бүлэгчлэлийн харьцаа өөрчлөгдөж, дотоод зодоон бий болдог. Тэгвэл одоо шат шатны хурлуудаар намын даргын асуудлыг ярихыг хориглож байгаа. Өөрөөр

хэлбэл, намын даргыг зөвхөн нийт гишүүд сонгодог, шат шатны хурлууд намын бодлогын асуудлыг шийдвэрлэдэг бол, гэж өөрчлөлтийн санал явж байгаа. Монголын ардчилал болоод АН хоёр нэг шугам дээр давахад ёстой гэж боддог. Сүүлийн жилүүдэд АН маань ардчилсан зарчмаасаа буюу үнэт зүйлээсээ хазайх тохиолдол цөөнгүй байлаа. Одоо харин АН-ыг өөрийнх нь үнэт зүйл, зарчим, үзэл бодол дээр эргүүлэн авч ирэх нь намын дүрмийн шинэчлэлийн энэ хурлын зорилго зорилт байх болно. АН шинэчлэгдсэнээр Монголын ардчилал шинэчлэгдэнэ. Ийнхүү монголын ардчилал шинэчлэгдсэнээр ирээдүй эрх чөлөө илүү баталгаатай болно гэж бид ойлгож байгаа.

УЛС ТӨР

СЭВЭЛЗҮҮЛЭХ ҮҮ

Р.Гончигдорж: Бүх асуудал гээр фракц байдаг



/УИХ-ын гишүүн асан/

-АН шинэчлэлийнхээ хөтөлбөрийг энэ Их хурлаараа хэлэлцэж байна. Шинэчлэлийн нэг чухал зүйл нь мэдээж хэрэг намын дүрмийн шинэчлэлийн асуудал юм. Дүрмийн шинэчлэлийн

асуудлыг хоёр үе шаттайгаар хийгдэж байгаа. Энэ удаагийн Их хурлаар намын дүрмийн шинэчлэлийг эхлүүлж, хамгийн түрүүнд намаа илүү нээлттэй болгохыг зорилго болгож байна. Тухайлбал, намын гишүүнчлэлийг илүү нээлттэй байх, намын удирдлагуудыг сонгох үйл ажиллагаа нээлттэй байх, намын бүх шатны байгууллагууд энэ чиглэлээрээ тодорхой хугацаанд хуралддаг, зөвлөлддөг байх хэрэгтэй. Харин асуудал нь орон нутгийн болоод улсын хэмжээний асуудлаа нээлттэй хэлэлцдэг

дүрэм, журамтай болох хамгийн эхний алхам нь юм. Уг нь АН өөрийн бодлого, үзэл баримтлалтай шүү дээ. Зүгээр л АН бодлогын нам болно гэж энгийн үгээр томъёолж яриад байгаа юм. Тиймээс бидний хэлэлцдэг асуудал ямар нэгэн дарга, цэргийн асуудал биш бодлогоо хэлэлцдэг бүх шатны намын байгууллагатай байх л зорилготой байна. Улс төрийн намуудын фракц гэж яриад байна. Асуудал нь юугаар фракцлах вэ гэдэг нь чухал асуудал юм. Түүнээс бүх асуудал дээр фракц байдаг.

Тухайлбал, гэр бүлд гэхэд л маргааш кино үзэх үү, дэлгүүр хэсэх үү, салхинд гарах уу гээд талцаж таараа шүү дээ. Үүнтэй нэгэн адил АН бодлогын нам гэдэг утгаараа хэлэлцэж буй асуудал дээрээ тодорхой хэмжээний фракциудыг бий болгож байна. Үүнээс нэг хэсэг нь цөөнх нөгөө хэсэг нь олонхи болно. Гэхдээ олонхи гэдэг утгаараа дулдуйдахгүй, цөөнх байлаа гээд хазайхгүй байх соёлтой байхыг л фракцгүй гэж тодотгоод байгаа юм.

Ц.Оюунгэрэл: АН илүү их нээлттэй болж байна



/УИХ-ын гишүүн асан/

-Өнөөдрийн /өчигдөр/ намын Их хуралд хэлэлцүүлэхээр оруулах дүрмийн өөрчлөлтийн төслийг ҮЗХ-оор хэлэлцэж дэмжээд, оруулж ирсэн. Ер нь гишүүд хийх гэж буй шинэчлэлүүдийг маш их дэмжиж үг хэлж байна. Яг одоо бол орон нутгаас ирсэн гишүүд үг хэлж байна. Намаа гишүүдээ эрх мэдэл олгосон буюу хаалга үүд нь нээлттэй өргөн хүрээнд хамтарч ажиллах чадах чадвартай нам болгох тал дээр олон гишүүн дэмжиж санал хэлж байна. Шинэчлэлийн хамгийн эхний

чиглэл нь намаа илүү нээлттэй болгохыг зориод байгаа юм. Нээлттэй нам болгоно гэдэг нь шийдвэр гаргахдаа хаалттай буюу хязгаарлагдмал төвшинд гаргадаг байсаныг илүү олон гишүүдийн оролцоотойгоор гаргахыг хэлж байгаа. Тиймээс шийдвэрүүд нь илүү нээлттэй гарна гэсэн үг. Тухайлбал, өмнө нь АН-ын даргыг ҮЗХ, Их хурал гээд удирдах төвшинд шийддэг байсан бол шинэ дүрмээр бол гишүүдийнхээ оролцоотой сугангаагаар намын даргаа сонгодог болох юм. Өнөөдөр хөдөө орон нутагийн жирийн гишүүдээс та АН дээр шийдвэр гаргах ямар үйл ажиллагаанд оролцох вэ гээд асуухаар ихэнх нь "мэдэхгүй" гэж хариулах болно. Тийм хэмжээнд манай нам гишүүдээсээ хаалттай болж байсан. Харин энэ Их хурлын дараа энэ асуулыг гишүүдээс асуухад маш тодорхой гурван эрх мэдэлтэй

гэж хэлнэ. Олон эрх мэдэл очиж байгаа. Гэхдээ хамгийн тодорхой нь гурван эрх мэдэл байна. Үүнд АН-д бүртгүүлсэн бүх гишүүд анхан шатны намын хорооны даргын сонгуульд шууд оролцож, санал өгнө. Энэ тохиолдолд татвар төлсөн эсэх нь хамаагүй. Бүртгэлтэй л бол болно. Хоёрдугаарт, АН-ын бүртгэлтэй татвараа төлөөд явж байгаа гишүүд илүү олон шатны таслах эрхийг эдэлнэ. Үүнд АН-ын даргын сунгаанд, ҮЗХ-ны сунгаанд, аймаг дүүргийн намын хорооны гишүүдийг сонгох сунгаанд тус тус таслах эрхтэй оролцоно. Ингээд ирэхээр гишүүдийн шийдвэр гаргах дээд төвшинд оролцох эрх мэдэл илүү их нэмэгдэж байгаа. Тиймээс ч АН илүү их нээлттэй болж байна гэж харагдаж байгаа. Энэ бол шинэчлэлийн нэг л чиг хандлага юм.

Х.Баттулга: Би намын дарга нэр гзвшихгүй



/УИХ-ын гишүүн асан/

-Манай намын их хурал олон жил болсонгүй. Энэ удаагийн хурлаар намынхаа доторх асуудлыг ярьж гэж байна. Тэгэхдээ шинэчлэл нэрийн дор явж байна. Хувь хүнд ч гэсэн шинэчлэл хэрэгтэй. Монгол Улс ч гэсэн шинэчлэгдэх болсон шиг байна. Бид 1990 онд нэг улсаас хараат байна, тусгаар тогтносон улсын чадамж алга гэж ярьж байсан. Одоо хөршөө сольчихсон чинь урд хөршөөсөө хамааралтай болчихлоо. Эдийн засаг болоод бүхий л шийдвэрүүд урд хөршөөсөө хамааралтай болсныг дүгнэж ярих хэрэгтэй болсон юм болов уу гэж бодож байна. Ганцхан манай нам ч биш. Монгол Улс тэр чигээрээ энэ талаар ярих ёстой болсон. Эдийн засгийн хараат боллоо, шийдвэр гаргаж чадахаа болилоо гэсэн зүйлүүдийг ярих байх. Миний бодлоор зөв. Яагаад гэвэл их хурлаар даргаа сонгодог. Нөгөө дарга нь таалагдахгүй бол фракциуд нь нийлдэг ч юм уу. АН-ын гишүүдээсээ сонгогдсон намын дарга нэлээд байр суурьтай, дэмжлэг авсан учраас зоригтой зүйлүүдийг хийгээд явчих болов уу гэсэн бодолтой байна. Ер нь чөлөөтэй шүү дээ. Энэ заалнаас ч хүн нэр дэвшиж болно. Би намын даргад нэр дэвшихгүй.

С.Ламбаа: АН-ын дүрэм угаасаа тийм муу дүрэм биш



/УИХ-ын гишүүн асан/

-Манай намын дүрэм угаасаа тийм муу биш. Учир нь бид 2000 онд АН-ын Их хурлыг таван нам нийлж хийхдээ маш сайн боловсруулж баталсан. Миний мөнхийн байр суурь бол энэ сайн дүрмээ өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлж чадаагүй. Ерөөсөө л хэн намын дарга болно тэр хүн өөрийнхөөрөө л явж байсан. Тиймээс өнөөдөр АН-ын нэр

хүндэд муугаар нөлөөлсөн янз бүрийн асуудал гарсан. Тиймээс энэ удаагийн Их хуралд бэлтгэх ажлын хэсэг 14 хоног ажиллаад эцэсдээ дүрэм шинэчилсэн наруулгаа болиод шинэчлэлийн хөтөлбөр, үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай болоод ороод ирлээ. Энэ бол яг цаг үетэйгээ тохирч байгаа юм. Өөрөөр хэлбэл, миний бодож явсантай бүрэн дүүрэн нийцэж байгаа. Ер нь бол өнөөдөр 1200 хүн хуралдаад л АН-ыг шинэчилчихнэ гэсэн зүйл байхгүй. Шинэчлэл нэлээд урт хугацаанд үргэлжилнэ. Тиймээс ч өнөөдөр Их хурлаараа эхний гурван сар үргэлжлэх юмыг хийх гэж байна. Үүнд намын

даргаа сунгаагаар сонгоно гэж байна. Дараа нь үүрээсээ эхлээд, ҮЗХ хүртэл бүх намын удирдлагын байгууллагуудыг бүгдийг нь татан буулгаад шинээр сонгоно гэж байна. Сонгох журмаа өнөөдөр батлах гэж байгаа. яагаад энэ бүгдийг хийж байгаа юм гэхээр намын үүрээсээ эхлээд, ҮЗХ хүртэл шат бүртгээ аймаг, сум, нийслэл, дүүргийн намууд чинь тодорхой нэг бүлэг хүмүүсийн өмчлөл рүү очоод байгаа. Тиймээс үүнийг задлах гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, жинхэнэ гишүүдээ АН-ын нь өгөх гэж байгаа. Та бүхэн намаа цааш нь аваад яв. Дарга, цэргээ хугацаанд нь дүрмийнхээ дагуу сонгож бай гэдгийг л хийж өгч байгаа юм.

Х.Тэмүцжин: АН фракцгүй нам болж чадвал сайн



/УИХ-ын гишүүн асан/

-АН-ын дүрмийн төсөлд үндсэндээ зургаан үндсэн өөрчлөлтийн багана байгаа. Манай намыг хамгийн их шүүмжилдэг, эв нэгдэлгүй өөр хоорондоо зөрчилддөг гэдэг. Зөрчил нь намынхаа хил хязгаараас халиад төрийн үйл хэрэг рүү орж ирдэг гэдэг шүүмжлэл байдаг. Тиймээс энэхүү дотоод зөрчилдөөнөө дотроо зөв зохистой шийдвэрлэх чадварт АН суралцахгүйгээр нэгдмэл нэг зорилттой нам байж чадахгүй

юм байна гэдэг нь харагдаж байгаа. Гэхдээ дотороо эв нэгдэлтэй байна гэдэг нь нэг нэгнийхээ буруу зөрүүг хааж, нуугаад явна гэсэн үг биш. Намуудын эв нэгдэлтэй байдал буюу нэгдмэл байр суурийг харахаар ардчилал сайн тогтвортой хөгжсөн улс орнуудын улс төрийн намуудын нэгдмэл байдлыг хангадаг гуравхан л зүйл байна. Нэгдүгээрт, маш тодорхой үзэл баримтлал буюу ямар үндсэн зарчим дээр нэгдсэн юм гэдгээ тодорхой болгох ёстой. Хоёрдугаарт, оролцоо буюу нээлттэй байдал эрүүл саруул оюун ухаанаар өрсөлдөх боломжтой дүрэм байх юм. Тэр дүрмийнхээ дагуу шийдвэр буюу бодлого гэсэн гурван зүйл дээр нэгдмэл байх тухай ярих ёстой.

Түүнээс эрх мэдэл албан тушаал, фракц, дарга тойрч нэгдэхийг нэгдмэл байдал гэж ойлгохгүй байгаа юм. Тиймээс ч АН энэ гурван зорилт дээр нэгдмэл байдлаа илэрхийлэх ёстой юм байна гэж харлаа. Энэ хүрээнд өнөөдөр дүрмийн том шинэчлэл хийхээс өөр арга байхгүй. Дүрмийн том шинэчлэл хийнэ гэдэг нь гишүүдээ нээлттэй оролцуулах, АН өөрөө үүд хаалгаа сайн нээж өгөхөөс гадна эрүүл саруул бодлогын өрсөлдөөн боддог нам болох ёстой юм байна гэж харж байгаа. ҮЗХ-оос томилсон дүрмийн ажлын хэсэгт би орж ажилласан. Дүрмийн ажлын хэсэг дээр зөвхөн хуучин улс төр болоод энэ намын түүхтэй амьдарлаа холбосон хүмүүсээс гадна

залуу, дунд ахмад үе гээд гурван үе оролцлоо. Энэ олон хүний шаардаж байгаа дүрмийн өөрчлөлтөд дээр хэлсэн үзэл санаанууд бүгд дууссан байгаа. Ер нь АН фракцгүй нам болж чадвал сайн. Бодит амьдрал дээр фракцгүй нам болно гэдэг хэцүү, төвөгтэй байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ эрх мэдэл тойрсон фракциасаа ядаж бодлогын салаа, мөчир болсон фракци болж хувирах нь АН өөрөө урт хугацаанд зөв явах алхам юм. Даргын асуудлыг энэ удаагийн хурлаар хэлэлцэхээр оруулаагүй. Учир нь Их хурлаар батлах дүрмээр даргыг нийт гишүүдээр сонгохоор төлөвлөж байгаа. Тэгээд сунгаан байдлаар ирэх хоёрдугаар сарын 20 гэхэд сонгогдоно гэсэн төлөвлөгөөтэй байна.



ЦАГ ҮЕ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Н.БАТЗАЯА

Монголын амьтан, ургамал судлаач эрдэмтэд байгаль орчин, аялал жуулчлалын яамны бодлогод өөрсдийн санаа бодлыг дэвшүүлж, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөлөө. Тодруулбал, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас “Эрдэмтдээ сонсье” ярилцлагыг өчигдөр зохион байгуулсан бөгөөд энэхүү уулзалтын үеэр эрдэмтэд Монгол орны амьтан, ургамлын талаар төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, өнөөгийн байдал, цаашид салбарын яамнаас баримтлах чиг хандлагын талаар хэлэлцсэн. Тус уулзалтад Байгаль орчин аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга Д.Даваасамба болон МУИС, МУБИС, ХААИС, Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, Геоэкологийн хүрээлэнгийн судлаачид, Байгалийн түүхийн музейн эрдэмтэд оролцов. Мөн олон улсын ирвэс хамгаалах сан, Зэрлэг амьтан судлах, хамгаалах нийгэмлэг зэрэг байгууллагын 40 гаруй эрдэмтэн, судлаачид оролцлоо. Уулзалтыг нээж, БОАЖ-ын сайд Д.Оюунхорол “Манай яам үндсэн чиг үүргийн яам болсноос хойш байгалийн нөөц, түүний дотор амьтан, ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, өсгөн үржүүлэх зэрэг асуудлаар салбар дундын зохицуулалт хийх үүрэг хүлээгээд байна. Бидэнд экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, бохирдол, доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх зэрэг олон тулгамдсан асуудлууд байна. Түүнчлэн Монгол орны ургамлын улаан данс, улаан номын бүртгэлд орсон нэн ховор, ховор 148 зүйлд олон улсын жишгээр үнэлгээ хийж үзэхэд угах орчны дарамт, хэт ашиглалтад 89 хувь нь өртсөн байна. энэ нь цаг уурын дулаарал, цөлжилт, бэлчээрийн талхлагдал болон уул уурхайн зохисгүй ашиглалт, хүний бруутай үйл ажиллагааны улмаас амьтан, ургамлын тархац нутаг хумигдан, биологич, үйлдвэрлэлийн нөөц илээс жилд хомсдож байгаа нь бодлогын хувьд шинэ менежмент бий болгох хэрэгтэйг харуулж байна” гэв. Үүний дараа хуралдаанд оролцсон эрдэмтэд өөрсдийн санаа бодлыг илэрхийлсэн юм. Эрдэмтэд нэн тэргүүнд хулгайн анчидтай тэмцэх, тогтвортой хөгжлийн бодлогод тулгуурлан амьтан, ургамлыг хамгаалах, судалгааны ажлыг хөгжүүлэх зэрэгт анхаарч ажиллах хэрэгтэйг салбарын сайдад сануулж байлаа. Ингээд эрдэмтдийн саналыг тоймлон хүргэе.

Н.Батсайхан:Хулгайн анчидтай бодлогын төвшинд тэмцэх хэрэгтэй

/МУИС-ийн Биологийн тэнхлийн багш, амьтан судлаач/

Манай улсад төдийгүй дэлхийд янз бүрийн хүчин зүйлээс хамаараад амьтдын нутаглах газар, нутаг хомсдож байна. Өөрөөр хэлбэл, уур амьсгалын өөрчлөлт, хүний нөлөөллөөс шалтгаалаад булаг шанд ширгэх, ус голын түвшин багасах, ойт нутаг хомсдох зэрэг асуудал тулгарч байна. Эко системийн олон янз байдал хумигдаж байна гэж нэг талаас ойлгож болно. Мөн манай улсад уул уурхайн олборлолт их явагддаг. Ялангуяа ховордсон амьтдын нутагладаг говь, цөлийн бүсэд ашигт малтмал ихээр илэрсэн. Үүнтэй холбогдуулан уул, уурхайн компаниуд ихэссэн. Говьд бидний сайн мэдэх хоёр бөхт зэрлэг хавтгай, мазаалай, хулан, хар сүүлт, бөхөн гэх мэтчилэн олон амьтад байдаг. Гэхдээ бид тоотой хэдэн амьтныг сорчилж хамгаалчихаад бусдыг нь орхих

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАЖ, ХУЛГАЙН АНЧИДТАЙ ТЭМЦЭХИЙГ ЭРДЭМТЭД ЗӨВЛӨВ



учир дутагдалтай. Цаашид ан амьтдыг хамгаалъя, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хамгаалъя гэвэл олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх хэрэгтэй. Үүний тулд Засгийн газрын бодлого чухал. Тэр дундаа хууль бус ангууртай тэмцэх Засгийн газрын бодлогын төвшинд авч үзэх хэрэгтэй. Яахав бодлогын төвшинд амьтдад тусгай хамгаалалттай газрыг гаргаж өгч байна. энэ чухал. Гэхдээ манай улсад нутаглаж буй амьтдад тулгамдаж буй нэн тэргүүний асуудал бол хулгайн ан агнуур. Энэ асуудалтай бид сүлжээ байгуулж л тэмцэх хэрэгтэй. Дан ганц байгаль хамгаалах явна гэвэл Монгол шиг уудам газар нутагтай оронд хэцүү л дээ.

С.Гомбобаатар: Амьтан хамгаалалд ганц улсын төсвөөр л санхүүжилт хийнэ гэвэл учир дутагдалтай

/МУИС-ийн Биологийн тэнхлийн профессор, шувуу судлаач/

Төрийн бодлого эрдэмтдийн санал бодол чухал байдаг. Энэхүү уулзалт эрдэмтдийнхээ санаа бодлыг сонсож, цаашид бодлогодоо тусгах гэсэн үр дүнтэй болж байна. Уулзалтад Монгол Улсын хэмжээнд судалгаа хамгааллын үйл ажиллагааг явуулдаг олон байгууллагууд оролцож байна. Манай салбарынханд маш олон асуудал бий. Тухайлбал, өндөр хүчдэлд шонхор болон махчин шувууд маш олноороо цохилж тухай асуудал байна. Мөн аргаль, янгирын лиценз гэх мэтчилэн олон асуудал бий. Үүнд эрдэмтэд өөрсдийн санаа бодлыг хэлэх байх. Мэдээж бидний хэлсэн санаачилсан ажлыг ажил хэрэг болгоход санхүү, мөнгө шаардлагатай. Гэхдээ ганц улсын төсвөөр санхүүжилт хийнэ гэвэл учир дутагдалтай. Манай

олон улсын байгууллагаас санхүүжилт авч байгаа байгууллагууд их бий. Тэгэхээр эдгээр байгууллагуудын хамтын ажиллагаа уялдаа холбоог яаж хангах вэ гэдгийг энэ уулзалтаар ярилцах байх. Тухайлбал, Монгол Улсын их сургууль, Лондонгийн амьтны нийгэмлэг хамтран зэрлэг амьтны хууль бус худалдааны чиглэлээр олон улсын төсөлт ажлыг хэрэгжүүлж байна. Хууль бус худалдаатай холбоотой асуудлыг яам санхүүжүүлэхээс илүүтэй төрийн бус болон олон улсын донор байгууллагууд санхүүжүүлдэг. Энэ ажлуудыг бодлогод хэрхэн тусгах вэ гэдэг чухал байна. Ер нь тусгах шаардлагатай ажлууд байгаа гэдгийг бид мэднэ. Тухайлбал, Засгийн газраас гаргасан нэн ховор ургамлын жагсаалт байна. Гэтэл тэр гаргасан нэн ховор ургамлын жагсаалт эргэлзээ төрүүлээд байдаг. Энэ асуудлыг бид ярилцаж, тодорхой төвшинд шийдэх хэрэгтэй. Би түрүүнд хэлсэнчлэн санхүүжилт нь яамнаас байх албагүй. Гэхдээ бодлогод нь судлаачдын үзэл санаа, санал шингэсэн байх ёстой. Тэгж байж аялал жуулчлал, байгаль орчны ажил тогтвортой явагдана.

Л.Пүрэвжав: Хилийн заагийг тогтоовол ирвэсийн нутаг бүрэн тусгай хамгаалалтад орно

/Олон улсын ирвэс хамгаалах сангийн менежер, амьтан судлаач/

Ирвэс хамгаалах одоогийн нөхцөл байдал ямар байна вэ. Ямар хамгаалалт маш чухал байна вэ? Эрдэмтдийг сонсон уулзалт урьдхийгдэж байгаагүй шинэлэг ажил байна. Ирвэсийн хувьд та бүхний мэдэж байгаа члан Тост тосон бумбын нуруут тусгай хамгаалалтад авсан. Гэхдээ эдсийн байдлаар хараахан болоогүй байна. Яагаад гэвэл хилийн заагийг тогтоох асуудал үлдсэн. Энэ асуудлыг тодорхой болгосны дараа тусгай хамгаалалтад бүрэн орсон

байна гэж үзэж байгаа. Хэрэв тусгай хамгаалалтад бүрэн орвол дэлхийн хэмжээнд 2025 он хүртэл 20 цоохор ирвэсийн бүс нутгийг хамгаална гэсэн. Үүний гурван бүс нутаг нь Монгол орны нэлээн том газар нутгийг хамарч байгаа. Энэ гурван бүсийн нэг нь говийн ландшафтын хэсэг юм. Ландшафтын төвшинд ирвэсийг хамгаалбал Монгол орон дахь ирвэсийн газар нутгийн нэлээд хэсэг нь хамгаалагдах юм.

Ирвэс хамгаалах арга хэмжээ тодорхой хэмжээнд явагдаж байна. Гэхдээ байгалийн хүчин зүйлээс шалтгаалаад ирвэс хоолгүйгэх тохиолдол гарч байна. Хамгийн сүүлд гэхэд Ховд аймагт ирвэсийн хоёр зулзага хоолгүйгэж, үхсэн тохиолдол гарсан шүү дээ?

Ховд аймгийн Дуут суманд ирвэсийн хоёр зулзага хоолгүйгэж үхсэн гэх мэдээллийг бид сонссон. Гэхдээ ерөнхийдөө цаг уурын өөрчлөлтөөс болоод цас, бороо орох ёстой цагтаа орохоо больсон. Хүний буруутай үйл ажиллагаа болон агаарын бохирдол, цаг уурын өөрчлөлтөөс хамаараад өвөл цас орохгүй байна гэдэг нь тухайн амьтны идэш, тэжээлд маш их нөлөөлдөг. Тухайлбал, ирвэс усгүйгэж, түүнээс болж харангатаж үхэх тохиолдол маш их сөргөөр байна. Бид байгалийн хүчин зүйлийг нэгэнт захирч чадахгүй. Тиймээс бид байгалийн хүчин зүйлийг даван туулахын тулд биотехникийн арга хэмжээг сайн авах хэрэгтэй. Жишээлбэл, аргаль, янгирт ус тавьж өгөх, булаг, шандын ус ширгэж байна. тэгэхээр амьтанд ус хэрэгтэй учраас байгалийн хүчин зүйлээр болохгүй байгаа учраас хүний хүчин зүйлээр хүний нөлөөллөөр оролцоотойгоор шийдвэрлэхээс өөр аргагүй болж байгаа юм.

Ирвэсийн хууль бусаар маш их агнадаг. Одоо хэрэгжиж байгаа хууль тогтоож хулгайн анчидтай тэмцэж, ирвэсийг хамгаалахад хэр түлхэц болж байна вэ?

Одоо хэрэгжиж байгаа Ан амьтны тухай хууль болон Ан агнуурын тухай хуулийг 1995 онд баталж, 2000 онд шинэчлэн

...Наад захын жишээ дурьдахад, тарвага агнахыг хориглосон боловч тарваганы зүй бус агналт тасралтгүй гарсан хэвээрээ л байгаа. Тарваганы хомсдол ч арилаагүй байх жишээтэй. Ийм маш олон жишээ дурьдаж болно. Хамгийн гол нь энэ нөөцийг яаж зохистой ашиглах вэ гэдэг улс орны бодлогын төвшин дэх маш чухал асуудал. Байгаль орчны салбарт хамгаалагч нь ашиглана, ашиглагч нь хамгаална гэсэн суурь концепци бий болчихоод байгаа юм...

найруулсан байдаг. Тиймээс эдгээр хуулийг одоогийн нөхцөл байдалд тааруулж, шинэчлэх шаардлагатай. Юм хөгжихийн хэрээр аливаа зүйлс хувьсан өөрчлөгдөж байдаг шүү дээ. Мэдээж тодорхой хугацааны дараа мониторинг хийгээд ч юм уу хуулийг өөрчлөх нь зайлшгүй. Ер нь одоогийн нөхцөл байдлыг хянан үзэж, хуулийн зарим зүйлийг өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах цаг нь болсон гэж үзэж байна.

Хулгайн анчидтай хамгийн түрүүнд тэмцдэг төрийн ажилчинд бол байгаль хамгаалагч нар байдаг. Гэтэл нэг сумд аймагт газар нутгаасаа хамаараад 1-2 байгаль хамгаалагч л ажилладаг. Тэгэхээр байгаль хамгаалагчдын орон тоог нэмэх шаардлага байна гэж харж байна л даа. Энэ тал дээр ямар байр суурьтай байдаг вэ?

Мэдээж энэ бол чухал асуудлуудын нэг. Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээнд оногдож байгаа байгаль хамгаалагчийн тоо хаана ч хүрэхгүй. Тухайлбал,

нэг байгаль хамгаалагч дээд тал нь 50-60 мянган га газрыг хамгаалдаг. Энэ бол нэг хүн өдөр бүр 50-60 мянган га газраар явахад хүч хүрэхгүй. Гэхдээ Монгол орны санхүүгийн байдал, яамны тусгай хамгаалалттай газрын бодлогын төвшинд үүнийг авч үзэх хэрэгтэй.

Р.Самьяа:Гадаадын иргэдэд ан агнуулдаг жуулчлагч компаниуд хориотой бүс нутагт эзэмшигч байдалтай

/МУИС-ийн Биологийн тэнхлийн багш, амьтан судлаач/

Дэлхийн улс орон бүрийн анхаарах ёстой нэг зүйл нь тогтвортой хөгжлийн асуудал. Тогтвортой хөгжлийн асуудал үндсэндээ маш олон зүйлийг хамаарна. Үүний доторх нэг чухал зүйл нь байгалийн нөөцийн зохистой ашиглалт байгаа юм. Байгалийн нөөц уул уурхай, газрын доорх баялаг, ургамал, амьтан гээд маш олон. Өнөөдрийн хэлэлцүүлгийн гол сэдэв нь ургамал, амьтны нөөц байна л даа. Тэгэхээр ургамал, амьтны нөөц өөрийн гэсэн онцлогтой. Байнга зөв зохистой ашиглаж чадах юм бол жил бүр өөрөө нөхөн төлжиж, олширч байдаг нөөц юм. Үүнийг зохистой хэмжээнд ашиглаж чадвал улс орны эдийн засагт хэрэгтэй. Хэрвээ ашиглалт, зохицуулалтыг зүй бусаар хийх юм бол энэ хомсдоно. Бүр устгаж алга болно. Ер нь манай улсад 1990 оноос хамгаалалт гэдэг асуудал нэлээд их яригдлаа. Тэгэхдээ хэтэрхий нэг тал руугаа туйлширчихсан юм. Хамгаалалтын цагдаах зохистой ашиглалтын талаархи асуудлыг цөөн ярьсан. Наад захын жишээ дурьдахад, тарвага агнахыг хориглосон боловч тарваганы зүй бус агналт тасралтгүй гарсан хэвээрээ л байгаа. Тарваганы хомсдол ч арилаагүй байх жишээтэй. Ийм маш олон жишээ дурьдаж болно. Хамгийн гол нь энэ нөөцийг яаж зохистой ашиглах вэ улс орны бодлогын төвшин дэх маш чухал асуудал.

Байгаль орчны салбарт хамгаалагч нь ашиглана, ашиглагч нь хамгаална гэсэн суурь концепци бий болчихоод байгаа юм. Энэ чинь дэлхийн аль ч улс оронд хэрэглэж байгаа. Тэгэхээр ангийн болон амьтны нөөцийг хэрхэн зөв зохистой ашиглах вэ гэхээр хууль бий болсонтой холбогдуулан нэг зохицуулалт бий. Ангийн бүс нутаг маань яах вэ гэвэл ан хийж болох нутаг гэсэн үг. Тэрийг орон нутаг өөрсдийнхөө шийдвэрээр бий болгож, тогтооно. Бусад газарт ан хийж болохгүй, хорниотой байх ёстой. Тэгэхээр үүнд ангийн бүс нутгаа хэн хамгаалах, яаж зөв зохистой зохицуулах вэ гэдэг асуудал гарч ирнэ. Уг нь концепцидоо орон нутгийн иргэд амьтны нөөцийг хамгаалах, түүнийгхээ үр шимийг өөрсдөө хүртэх хэрэгтэй гэдэг. Өнөөдрийн байдлаар эрхгүйн зохицуулалт арай өөрөөр яваад байна. Ялангуяа гадаадын анчдад аргаль, янгир агнуулдаг жуулчлагч компаниуд хөрөнгийн чадвартай, мэдээлэлд ойрхон, хаана ан байна тэр бүс нутагт эзэмшигч байдалтай болоод энд, тэндээс очиж, түүвэрлэх байдалтай байгаа юм. Тэр хүмүүс орон нутгийн байгалийн нөөцөд онцгой анхаарахгүй. Очоод зөвхөн үр шимийг нь хүртэхийг л бодож байгаа. Тэгэхээр зохицуулалт тааруу байна. Ер нь зарчимдаа орон нутгийн иргэд ангийн бүс бүс нутгаа эзэмшиж, хамгаалж, зохистой ашиглан үр шимийг нь өөрсдөө хүртэх ёстой. Ингэж байвал тогтвортой ашиглалт. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал. Энэ чиглэл рүү л бид явах ёстой. Цаашид энэ чиглэлд юу хийх ёстой талаар ярилцах нь чухал. Хэрвээ зохистой ашиглаж чадах юм бол байгалийн байгаль тасралтгүй л үр шимээ өгнө. Гэхдүү түүнийг л зөв ашиглах хэрэгтэй.

ДЭЛХИЙ

Хууль бус Элчин сайдын яам ажиллаж байжээ

Гана улсын нийслэл Аккрад хэсэг луйварчин АНУ-ын Элчин сайдын яамыг хуурамчаар байгуулан, хүмүүсийг залилан мэхэлдэг байсан нь илэрчээ. Хуурамч Элчин сайдын яам долоо хоногийн даваа, мягмар, баасан гарагт 7:30-12:00 цагийн хооронд үйл ажиллагаагаа явуулдаг байсан бөгөөд тус барилгын гадна АНУ-ын далбаа намрич, дотор нь Ерөнхийлөгч Барак Обамагийн зураг хүртэл өлгөөтэй байдаг учир хүмүүс АНУ-ын Элчин сайдын яам гэдэгт итгэдэг байжээ. Саяхан АНУ-ын албаныхан мэдэгдэл хийж хуурамч Элчин сайдын яамыг Гана, Туркийн хамтарсан гэмт хэргийн бүлэглэл ажиллуулж байсныг дурьдаад, дотоодын нөлөө бүхий хүмүүс ч энэ хэрэгт оролцсоныг мэдэгдлээ. Энэ хуурамч элчин сайдын яамаар дамжуулан хууль бусаар цагаачлалын бичиг баримт

үйлдэн, виз хүртэл гаргадаг байжээ. Англи, Голланд хэлтэй туркууд консулын ажлыг эрхэлдэг байсан аж. Тэд Африкийн алслагдмал бүсээс үйлчлүүлэгчдээ сонгож хуурамч виз гаргадаг байжээ. Тэдний үйлчлүүлэгчдийн ихэнх нь Зааны ясан эрэг болон Того улсын иргэд бөгөөд хуурамч бичиг баримт гаргаж өгөхдөө 6000 ам.доллар шаарддаг байжээ. Хуурамч элчингийн байрыг шалгахад, орон орны 150 гадаад паспорт, АНУ, Шенген, Энэтхэг, Өмнөд Африкийн хуурамч визүүд илэрчээ.

Хэдийгээр луйврын газрыг хаагаад байгаа ч мөрдөн байцаалтын ажил хараахан дуусаагүй байна. Арав гаруй жил үйл ажиллагаа явуулж ирсэн энэхүү хуурамч Элчин сайдын яам Гана улсын албаныханд хахууль өгснөөр хууль бус үйлдлээ үргэлжлүүлж чаддаг байжээ.

Фужимори эмнэлэгт хэвтжээ



Шоронд хоригдон ял эдэлж буй Перугийн экс Ерөнхийлөгч Альберто Фужимори толгой нь эргэж, биеийн байдал нь муудсаны улмаас эмнэлэгт хүргэгджээ. Энэ талаар орон нутгийн сонинд мэдээлсэн байна. Перугийн ерөнхийлөгч асан Альберто Фужимори хоёр хүнийг хулгайлан, амийг нь хороосон хэргийг зохион байгуулсан гэх үндэслэлээр дээд шүүхээс 25 жилийн ял сонсч, шоронд хоригдсон билээ. Гэвч эдүгээ аль хэдийн 78 насны босго алхсан түүний биеийн байдал нь муудаж

эмнэлэгт хүргэгдсэн байна. Фужиморигийн тархины цусны эргэлт муудснаас гадна баруун мөр нь хөдөлгөхөд бэрхшээлтэй болжээ.

Тэрбээр Перугийн ерөнхийлөгчөөр 1990-2000 онд гурван удаа сонгогдож байсан юм. Улмаар 2000 онд улс төрийн систем нь хямарсны дараа Японд орогнол хүсч очсон юм. Тэрбээр 2005 онд Чилид очих үеэрээ баривчлагдаж хагас жилийн дараа барьцаагаар суллагдсан боловч 2007 оны есдүгээр сарын 22-нд Чилиэс Перуд хүргэгдэж байв.

Мануэль Валлис Ерөнхийлөгчид хүч үзнэ

Энэ сар гарсаар барууны хэд хэдэн улсын Ерөнхий сайд ээлж дараалан огцрох мэдэгдлийг хийгээд байна. Мэдээж тэдний огцорсон шалтгаан янз бүр. Эхлээд Италийн Ерөнхий сайд Маттео Ренци тус улсад явагдсан бүх нийтийн санал асуулгын дүн гарсны дараа огцорсон. Бүх нийтийн санал асуулгаар түүний сенатчдын эрх мэдлийг хязгаарлах санаачилга биеллээ олох эсэх



нь шийдэгдэх байсан нь иргэдийн дийлэнх нь "Үгүй" гэх хариултыг сонгосноор тэрбээр суудлаасаа буусан юм. Түүний халааг Шинэ Зеландын Ерөнхий сайд залгамжилсан. Шинэ Зеландын Ерөнхий сайдын албыг найман жилийн турш хашсан нэр хүндтэй улстөрч Жон Ки мөн л огцорч буйгаа мэдэгдсэн билээ. Түүний хувьд огцрох шалтгаанаа гэр бүлийн

байдалтай холбон тайлбарласан бөгөөд түүний гэнэтний мэдэгдэл улстөрчдийг шоконд оруулсан удаатай. Тэгвэл тэдний халааг Францын Ерөнхий сайд үргэлжлүүллээ. Францын Ерөнхий сайд 54 настай Мануэль Валлис өнөөгийн Ерөнхийлөгч Франсуа Олландыг залгамжилж, ирэх оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээ мэдэгдсэн байна. Тэрбээр эрх баригч Социалист намын ирэх сард болох урьдчилсан шатны сунгаанд нэр дэвших бөгөөд ингэхийн тулд өчигдөр албан ёсоор суудлаасаа буужээ. Намаас сонгуульд нэр дэвшихийг сонгох урьдчилсан шатны сунгаа ирэх нэгдүгээр сарын 22 болон 29-ний өдрүүдэд явагдах билээ. Францын Ерөнхийлөгчийн сонгуульд олон нийт өнөөгийн Ерөнхийлөгч Франсуа Олландыг улиран сонгогдохоор өрсөлдөнө хэмээн таамаглаж байсан. Гэсэн ч тэрбээр сонгуульд оролцохгүй гэдгээ орон нутгийн телевизээр мэдэгдэл хийхдээ онцолжээ. Эдүгээ 62 насны босго алхсан Франсуа Олланд Францын түүхэн дэх хамгийн рейтинг муутай төрийн тэргүүний нэг байсны зэрэгцээ сонгуульд улиран нэрээ дэвшүүлээгүй анхны Ерөнхийлөгч болж байна. Тэрбээр "Үүрэгт ажлаа өгөхөөс өмнөх хэдэн сарыг улсаа удирдахад л зориулна. Намайг Ерөнхийлөгч байх хугацаанд дэлхийн хэмжээнд, Европ тивд, манай улсад маш ноцтой зүйл олон тохиолдлоо. Би энэ хэцүү үед улсынхаа аюулгүй байдал, уялдаа холбоог л сайжруулахыг хүссэн" хэмээн юм. Франсуа Олландын үед Францад хэд хэдэн ноцтой халдлага гарсан. Өнгөрсөн жилийн долдугаар сард Ницца хотод, арваннэгдүгээр сард Парист террорист халдлага болсон. Түүнээс хойш Франц улс байнгын өндөржүүлсэн бэлэн байдалд буй билээ. Ямартай ч, хамгийн сүүлд явуулсан санал асуулгын дүнгээр Мануэль Валлис нам доторх сунгаанд ялах өндөртэй ч, ирэх жилийн дөрөвдүгээр сард явагдах Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд Үндэсний фронт намын Марин Ле Пен, Франсуа Фийон нарт ялагдах төлөвтэй байна.

Б.ДАВААХҮҮ

ЗХУ-ын бүрэлдэхүүн эздрэн унасны дараа буюу 1990 оноос эхлэн Узбекистан улсыг 25 жилийн турш хатуу гарын дор нэгтгэн удирдсан Ислам Каримов өнгөрөгч есдүгээр сарын эхээр тархиндаа цус харваж, хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн юм. Түүнээс хойш тус улсын төрийн тэргүүний үүргийг Ерөнхий сайд Шавкат Мирзияев түр орон гүйцэтгэж байсан билээ. Тэгвэл энэ сарын 4-нд тус улсад Ерөнхийлөгчийн ээлжит бус сонгууль явагдаж, эртнээс ажиглагчдын магадлал өндөртэй хэмээн таамаглаж байсан Шавкат Мирзияев үнэмлэхүй олонхийн саналаар сонгогдож, Узбекистан улсын хоёр дахь Ерөнхийлөгчөөр тодорчээ. Сонгууль өглөөний 06.00 цагт орон даяар эхэлж, 20.00 цагт өндөрлөн тооллогын ажиглагаа үргэлжилж, маргааш өдрийн өглөө гэхэд үр дүн нь тодорхой болсон байлаа. Түүнчлэн, 32 сая хүн амтай тус улсад нийтдээ 9383 хэсгийн хороод ажиллажээ. Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Төв Азийн улсуудаас хамгийн их хүн амтай нь гэдэг утгаар Узбекистаны Ерөнхийлөгчийн сонгуулийг олон улс анхааралтай ажиглаж байлаа. Ерөнхийлөгчийн сонгуульд дөрвөн хүн нэр дэвшжээ. Тодруулбал, Ерөнхий сайд Шавкат Мирзияеваас гадна

ШАВКАТ МИРЗИЯЕВ УЗБЕКИСТАНЫ ХОЁР ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР СОНГОГДЛОО

Узбекистаны Ардын ардчилсан намаас Хотамжан Кетмонов, "Милли тикланиш" намаас Сарвар Отамурадов болон "Адолат" Социал демократ намаас Нариман Усманов нар сонгуульд тус тус өрсөлдөв. Улмаар сонгуулийн эцсийн дүн гарахад, Ислам Каримов агсны бодлогыг үргэлжлүүлнэ гэдгээ амласан Ш.Мирзияев 88,6 хувийн саналаар үнэмлэхүй ялалт байгуулж, Узбекистан улсын хоёр дахь Ерөнхийлөгчөөр тодорчээ. Тус улсын 25 жилийн турш удирдсан Каримов энэ оны есдүгээр сард таалал төгссөний дараа түүнийг хэн залгамжлах нь олон улсын анхаарлыг татаж эхэлсэн байдаг. Тухайн үед ажиглагчид хамгийн боломжит хувилбар нь Ерөнхий сайд Ш.Мирзияев

хэмээж байлаа. Харин энэ удаагийн сонгуульд ялалт байгуулснаар тэрбээр таван жил улсын Ерөнхийлөгчийн албан тушаалыг хашхаар болов. Түүний ялалтын мэдээ тарсны дараа ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Узбекистаны шинэхэн Ерөнхийлөгч рүү өөрийн биеэр залгаж, баяр хүргэсний зэрэгцээ Орос улсад айлчлахыг урьсан байна. Ш.Мирзияев 2003 оноос хойш Засгийн газрыг тэргүүлж байгаа энэ эрхэм 2001-2003 онд Самаркандын засаг дарга, 1996-2001 онд Жизикын засаг даргаар ажиллаж байжээ. Ш.Мирзияев Каримов агсны гэр бүлтэй ойроос гадна Оросын сонирхолд хамгийн их нийцдэг хүн гэгддэг аж. Түүнчлэн, өмнөх удирдагчаас ч илүү харгис бодлого явуулж болзошгүй гэж ажиглагчид таамагладаг билээ.

Ш.МИРЗИЯЕВ ГЭЖ ХЭН БЭ

Узбекистаны хоёр дахь Ерөнхийлөгч Ш.Мирзияев 1957 оны долдугаар сарын 24-нд төржээ. Тэрбээр 1981 онд Ташкентийн коллежийг төгсч байсан бөгөөд технологийн шинжлэх ухааны доктор зэрэгтэй гэнэ. Ш.Мирзияев 1996-2001 онд Жизикын Засаг даргаар, 2001 оны есдүгээр сараас 2003 он хүртэл Самаркандын засаг даргаар тус тус ажиллаж байгаад мөн оноос эдүгээг хүртэл Ерөнхий сайдын албыг хашиж, Узбекистаны Ислам Каримовын баруун гарын үүргийг гүйцэтгэж байжээ. Экс Ерөнхийлөгч Ислам Каримов түүнийг өөрөө Ерөнхий сайдын албан тушаалд нэрийг нь дэвшүүлж, тус улсын парламентаар баталгаажуулж байсан байна. 2006 оны есдүгээр сарын 25-нд тэрбээр Ташкент хо тноо БНСУ-ын тухайн үеийн Ерөнхий сайд Хан Мён Сукийг хүлээн авч уулзан хэд хэдэн хөдөө аж ахуйн гэрээл хэлэлцээрийг үзэглэсэн. Үүний нэг нь 2010-2014 хүртэл жил бүр Узбекистан улс 300 тонн уран экспортлох гэрээ байсан юм. Мөн 2005-2006 онд БНСУ, Узбекистаны худалдаа 40 орчим хувиар нэмэгдэж, 565 сая ам.долларт хүрч байв.

“БАТЛАН ХАМГААЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН НЭГДЭЛ” ТӨҮГ АВТОБУС НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛНА

Солонгос улсад үйлдвэрлэсэн дизель хөдөлгүүртэй, 2 хаалгатай, хүн зөөврийн зориулалттай /34-өөс

доошгүй хүний суудалтай/ Монголын нөхцөлд тохиромжтой автобус 2 нэгжийг яаралтай худалдаж авна.

Материал хүлээн авах хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл.
Хаяг: Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, Дандарбаатарын гудамж-51, Засгийн газрын 7 дугаар байрны дэргэд, БХАҮН ТӨҮГ-ын байр.
Холбоо барих утас: 70164555, 99181100, 99519196

NO STRESS

ДУУЛГАХ СОНИН

Б.ГАНГААМАА ВИНСОН МАССИФ УУЛАНД ЦЭНГҮҮЛЭХ ТӨРИЙН ДАЛБААГАА ГАРДАЖ АВЛАА

Э.ТУУЛ

Монгол Улсын гавьяат тамирчин, уулчин Б.Гангаамаа дэлхийн долоон тивийн ноён оргилын зургааг нь эзлээд байгаа билээ. Тэрбээр зургаа дахь тивийн ноён оргил Карстенз Пирамид буюу Пункак Жаяа оргилд долдугаар сард төрийн далбаагаа мандуулсан юм. Карстенз нь дэлхийн долоон тивийн ноён оргилын нэг бөгөөд далайн төвшнөөс 4884 метрт өргөгдсөн хадан уул юм. Энэ оргилд урьд өмнө нь Монгол хүн авирч байгаагүй гэдгээрээ онцлогтой. Тэгвэл дэлхийн долоон тивийн ноён оргилын зургааг нь эзэлж чадсан уулчин бүсгүй Антрактид тивийн ноён оргил болох 4897 метрийн өндөртэй Винсон Массифыг эзлэхээр энэ сарын 13-нд хүлгийн жолоо залах гэж буй. Энэхүү оргилд авирах болсон нь түүний хувьд Антрактид тивд зочилсон ес дэх монгол иргэн, анхны монгол эмэгтэй уулчин болж байгаагаараа онцлогтой юм. Тэрбээр авиралтаа 15-нд эхлүүлж, нийт 15 хоногийн хугацаанд авиралтаа дуусгахаар төлөвлөөд байгаа аж. Мөн авиралтаа хийхийн зэрэгцээ Хойд туйлын цаг уур, орчны

судалгаа, цас мөсний хэмжилт хийх зэрэг судалгаа-шинжилгээний ажлыг давхар хийх гэнэ. Монгол Улсын гавьяат тамирчин, уулчин Б.Гангаамаа “Би өнгөрсөн есдүгээр сард авиралтынхаа тухай зарлаж, хандив цуглуулж эхэлсэн. Олны дэмжлэг хандиваар зорилгоо биелүүлэх боломжтой боллоо. Энэ удаагийн авиралтыг ОХУ-ын “7 Summits” клуб зохион байгуулж байгаа. Оросын багтай явах учраас гайгүй байх аа” хэмээжээ. Түүнчлэн Монгол Улсын гавьяат тамирчин, уулчин Б.Гангаамааг өчигдөр УИХ-ын гишүүн Д.Хаянхярваа хүлээн авч, Винсон Массифд мандуулах төрийн далбааг гардуулан өгсөн юм. Энэ талаар гавьяат тамирчин, уулчин Б.Гангаамаа өөрийн фэйж хуудсандаа тэмдэглэж, “Өнөөдөр Антрактид тивийн ноён оргил Винсон Массиф ууланд цэнгүүлэх төрийн далбаагаа гардаж авлаа. Бүтэн гурван сарын аян амжилттай өндөрлөж, миний бие та нарыгаа төлөөлөн Цагаан тивийг зорих боллоо. Баярлалаа та бүхэндээ” хэмээн сэтгэгдлээ үлдээжээ. Дашрамд дурьдахад, одоо Антрактид тивд зун болж байгаа бөгөөд зундаа -30 хэмийн хүйтэн байдаг ажээ.



Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -13
Шөнө -22

Нөгөөдөр
Өдөр -14
Шөнө -26

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал: *Нас уртасна.*
Наран ургах, шингэх: *08.28-17.05*



Тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сан тавиулах, угаал үйлдэх, нялхасын хурим хийх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худаг гаргах, сэтгэлд сэтгэй газар очих, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Их цасан унах улирал 1 цаг 55 минутад эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртадна.

FOOTBALL NEWS



БЕЙЛ хөгжөөн
дэмжигчиддээ
хандаж видео
мэндчилгээ
илгээлээ

Н.ПУНЦАГБОЛД

Испанийн алдарт “Реал Мадрид” клубын довтлох чиглэлийн хагас хамгаалагч багийнхандаа болоод хөгжөөн дэмжигчиддээ хандаж видео мэндчилгээ илгээжээ. Тэрбээр “Миний нөхөн сэргээх

эмчилгээ сайн болж байгаа. Өдрөөс өдөрт шагайны бэртэл дээрдж л байна. “Боруссия Дортмунд”-ын эсрэг тоглолтод багийнхандаа амжилт хүсье. Би гэртээ тоглолтыг үзэх болно. Амжилт хүсье, Мадрид” хэмээжээ. Бейл ирэх оны дөрөвдүгээр сараас нааш талбайд гарахааргүй болсон билээ.

СОНИРХУУЛАХАД

МЭРАЙ КЭРИ майз бүжигчинтэйгээ учир ургуулжээ

Дуучин Мэрай Кэри тайзны бүжигчинтэйгээ учир ургуулжээ. Саяхан буюу өнгөрөгч аравдугаар сард тэрбумтан сүйт залуу Жэймс Пакерт хаягдсан тухай барууны шар хэвлэлүүд хэсэгтээ л шуугисан. Австралийн тэрбумтан Жэймс Пакер түүнтэй сүй тавьж, 10 сая ам.долларын үнэтэй алмаазан бөгж хүртэл бэлэглэсэн юм. Гэвч тэдний харилцаа удалгүй дууссан.

Тэгвэл сүйт залуугаасаа салснаас хойш төд удалгүй дуучин бүсгүй тайзны бүжигчин япон гаралтай Брайн Танака гэгчтэй учир ургуулж эхэлжээ. Тэдний далайн эрэгт үнслэж буй зураг шар хэвлэлүүдэд хэдийнэ зарларнаас гадна саяхан болсон тоглолтынхоо үеэр ч бүсгүй дотно харилцаагаа шүтэн бишрэгчдээсээ нуухыг хүсээгүй гэнэ.

Бидэнд тохиолдсон




Henmedeh Hurelbaatar

Эхнэртэйгээ дөнгөж нийлээд байтал хоёрдугаар сарын 14 болов оо. Цалин мөнгө бага болохоор есөн ширхэг сарнай боолгоод л, сүртэй бөгж аваад л набортой ажил дээр нь аваад очив. Ажил дээрээ их сүртэй додигор авсан юм. Тэгсэн чинь харин гэрт ирснээ “Юун өвс аваад мөнгө үрээд байгаа юм” гээд загнуулдаг байна шүү дээ. Тэгээд одоо цэцэг авах гэхээр нэг л сонин, загнуулах юм шиг санагдаад байдаг юм.

ТЭНГИС
KINO LEATP

Өөрөөс нь урвасан цус сорогчдын бүлэг болон хүн чононуудын хоорондох эцэс төгсгөлгүй дайныг дуусгах эцсийн дайралт хийнэ.



Аав хүү хоёр хайрт хань, хайрт ээжээсээ хагацаад хоёр жилийг үджээ... Аав жижигхэн шорлогны газар ажиллана. Харин хүү цэцэрлэгийн алба хашина. Ээжийг нь бурханы оронд очсоноос хойш аав хүү хоёр ээжийн талаар ярилцахгүй байхаар тохирсон хэдий ч бяцхан хүүгийн сэтгэлээс ээж хоромч салаагүй юм.



УДАХҮЙ ДЭЛГЭГНЭЭ

ТЭНГИС АППЛИКЕЙШН ТАНАГАР УТСАНД

Google play, App Store, Telegram movie theater

НЭГ КИНО ҮЭЭД 1 ОНОО НЭМҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ

ТЭНГИС КИНОБЛЕТИЙН КАРТ

5 ОНОО ЦЭЦЭГЭЭД 50% ХӨНГӨРӨЛТ ЭДЛЭХ БОЛОМЖТОЙ

ТАСАЛБАРЫН ҮНЭ

Мягмар, Лхагва, Пүрэв гаригт
2000 ТӨГ
Бусад өдөрүүдэд
3000 ТӨГ

НАЙМАН ӨДӨР БҮРИЙН ЭХНИЙ ҮЗВЭР МЯГМАР, АЖАГВА ГАРИГТ БҮХ КИНО

Уугал Попперн, Тасалбарыг Алаах

ТОМ ХҮН ХҮҮХЭД
5,000Т 4,000Т